**Гунтер Хаузер**

# ЕВРОПЫН ОРНУУДЫН ТӨВИЙГ САХИХ, ЭВСЭЛД ҮЛ НЭГДЭХ БОДЛОГО

XXI зууны эхэнд Европ дахь төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч орнуудын аюулгүй байдлын бодлогод тулгарч буй сорилт

Конрад-Аденаур Сангаас ивээн тэтгэж хэвлүүлэв.

Стратегийн судалгааны хүрээлэнгээс эрхлэн орчуулж гаргав.

*Хянан тохиолдуулсан:* *Д.Мөнхтөр*
*Герман хэлнээс орчуулсан:* *Ч.Нарантуяа,*
*Ж.Адъяасүрэн*
*Эмхэтгэсэн:* *Л.Бямбаханд*

*Хэвлэлийн хуудас: 4.5*
*Монгол орчуулгын эрх © Стратегийн судалгааны хүрээлэн*
*Улаанбаатар, 2016*

*Зөвшөөрөлгүй хувилж олшруулах, хэсэгчлэн авч ашиглах, хэвлэн нийтлэхийг хориглоно.*

**Гунтер Хаузер**

# ЕВРОПЫН ОРНУУДЫН ТӨВИЙГ САХИХ, ЭВСЭЛД ҮЛ НЭГДЭХ БОДЛОГО

XXI зууны эхэнд Европ дахь төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч орнуудын аюулгүй байдлын бодлогод тулгарч буй сорилт

Barbara Budrich- хэвлэлийн газар,
Opladen • Berlin • Toronto 2015

“Олон улсын аюулгүй байдлын асуудлаарх эрдэм шинжилгээний форум” холбоо, Хамбург дахь Хелмут Шмит-ийн нэрэмжит их сургууль/Бундесверийн их сургуулийн Проф. Др. Михайл Штаак эрхлэн гаргав.

# Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.......................................................... 4

1. Оршил .......................................................................................7
2. Төвийг сахихын учир холбогдол ........................................7
3. Төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч орнуудад учрах аюул занал ............................................................................ 12
4. Туслан дэмжих үүрэг, эвсэлд үл нэгдэх болон төвийг сахих ............................................................................19
5. Эв нэгдлийн заалт ..............................................................21
6. Австри улсын төвийг сахих бодлого ................................ 53
7. Эвсэлд үл нэгдэх ба Төвийг сахих бодлого - Швед, Финлянд, Ирланд, Мальта ................................................... 31
   7.1 Швед улс ...................................................................... 31
   7.2 Финлянд ...................................................................... 34
   7.3 Ирланд .........................................................................39
   7.4 Мальта улс ..................................................................43
8. Серб, Молдав улсууд төвийг сахигч мөн үү? ................... 45
9. Украин: онцгой тохиолдол ................................................ 49
10. Дүгнэлт ............................................................................. 56

Ном зүй ...................................................................................... 63

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| AEUV | (Vertrag über die Arbeitsweise der Europäischen Union) – Европын холбооны үйл ажилагааны тухай гэрээ |
| BMEIA | (Bundesministeriums für Europa, Integration und Äußeres)- Европ, Интеграц, Гадаад хэргийн асуудал эрхэлсэн холбооны яам |
| BMLVS | (Bundesministerium für Landesverteidigung und Sport) - Холбооны батлан хамгаалах, спортын яам |
| BM.I | (Bundesministerium für Inneres) – Холбооны дотоод хэргийн яам |
| B-VG | (Bundes-Verfassungsgesetz) – Холбооны Үндсэн хууль |
| BZÖ | (Bündnis Zukunft Österreich) – Австрийн Ирээдүй эвсэл |
| CPLP | (Gemeinschaft der portugiesisch-sprachigen Länder) – Португал хэлт улсуудын нийгэмлэг |
| DCFTA | (Deep and Comprehensive Free Trade Area) – Гүнзгийрүүлсэн, иж бүрэн чөлөөт худалдааны бүс |
| DRK | (Demokratische Republik Kongo) – Бүгд найрамдах ардчилсан Конго улс |
| EFTA | (European Free Trade Association) – Европын чөлөөт худалдааны нийгэмлэг |
| EG | (Europäische Gemeinschaft) – Европын нийгэмлэг |
| ER | (Europäischer Rat) – Европын зөвлөл |
| ESS | (Europäische Sicherheitsstrategie) – Европын аюулгүй байдлын стратеги |
| ESVP | (Europäische Sicherheits- und Verteidigungspolitik) – Европын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого |
| EU | (Europäische Union) – Европын холбоо |
| EUV | (EU-Vertrag in der Fassung des Vertrags von Lissabon) – Европын холбооны гэрээ (Европын холбооны гэрээний Лиссабонд баталсан хувилбар) |
| EVA | (Europäische Verteidigungsagentur) – Европын батлан хамгаалах агентлаг |
| EVP | (Europäische Volkspartei) – Европын ардын нам |
| FPÖ | (Freiheitliche Partei Österreich) – Австрийн эрх чөлөөний нам |

| | |
|---|---|
| GASP | (Gemeinsame Außen- und Sicherheitspolitik) – Гадаад бодлого, аюулгүй байдлын нэгдсэн бодлого |
| GSVP | (Gemeinsame Sicherheits- und Verteidigungspolitik) – Аюулгүй байдал, батлан хамгаалахын нэгдсэн бодлого |
| GUS | (Gemeinschaft Unabhängiger Staaten) – Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг |
| ISAF | (International Security Assistance Force) – Олон улсын аюулгүй байдлыг дэмжих хүчин |
| ISIS | (Islamischer Staat im Irak und in Syrien) – Ирак, Сирийн нутаг дахь Исламын улс бүлэглэл |
| ISIL | (Islamischer Staat im Irak und in der Levante) – Ирак, Левант дахь Исламын улс бүлэглэл |
| KFOR | (Kosovo Force) – Косово дахь энхийг сахиулах хүчин |
| KPdSU | (Kommunistische Partei der Sowjetunion) – ЗХУ-ын Коммунист нам |
| mil-CERT | (Military Computer Emergency Readiness Team)- Цэргийн мэдээллийн технологийн шуурхай бэлэн байдлын баг |
| MoU | (Memorandum of Understanding) – Харилцан ойлголцлын санамж бичиг |
| NATO | (North Atlantic Treaty Organization) – Умард Атлантын гэрээний байгууллага |
| NC3A | (NATO Consultation, Command and Control Agency) – НАТО-гийн зөвлөлгөө, удирдлага, хяналтын агентлаг |
| NRF | (NATO Response Force) – НАТО-гийн өндөржүүлсэн бэлэн байдлын хүчин |
| NORDEFCO | (Nordic Defence Cooperation) – Скандинавын орнуудын батлан хамгаалах хамтын ажиллагаа |
| OCC | (Operational Capabilities Concept) - Зэвсэгт хүчний хамтран ажиллах чадвар, стандартчиллын хөтөлбөр |
| OECD | (Organization for Economic Co-operation and Development) –Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага |
| OEEC | (Organization for European Economic Co-operation) – Европын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага |

| | |
|---|---|
| OSZE | (Organisation für Sicherheit und Zusammenarbeit in Europa) – Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага- ЕАБХАБ |
| ÖIIP | (Österreichisches Institut für Internationale Politik) – Австрийн Олон улсын бодлогын хүрээлэн |
| ÖSS | (Österreichische Sicherheitsstrategie) – Австрийн аюулгүй байдлын стратеги |
| ÖVP | (Österreichische Volkspartei) – Австрийн ардын нам |
| PARP | (Planning and Review Process) – Төлөвлөлт, хяналтын процесс |
| PfP | (Partnerschaft für den Frieden) – НАТО-гийн Энхийн төлөө түншлэл |
| SPÖ | (Sozialdemokratische Partei Österreich)- Австрийн социалдемократ нам |
| SSR | (Sicherheitssektorreform) – Аюулгүй байдлын салбарын шинэчлэл |
| UdSSR | (Union der Sozialistischen Sowjetrepubliken) – Зөвлөлт социалист бүгд найрамдах холбоот улс |
| UKRPOLBAT | (Ukrainisch-Polnisches Bataillon) – Украин, Польшийн батальон |
| VN | (Vereinte Nationen) – НҮБ (Нэгдсэн Үндэстний байгууллага) |

# 1. Оршил

Төвийг сахих болон эвсэлд үл нэгдэх гэдэг нь болзошгүй дайнаас үүдсэн, эрх зүй, улс төрийн агуулга бүхий ойлголт бөгөөд улс орон бүр үүнийг харилцан адилгүй тайлбарлаж байгаа талаар энэхүү номд өгүүлнэ. Төвийг сахих бодлого нь 1907 оны *Хаагийн V, XIII дугаар Конвенцид* заасан эрх зүйн зарчимд тулгуурладаг бол Эвсэлд үл нэгдэх бодлогод эрх зүйн ямар нэг хязгаарлалт ерөнхийдөө үгүй юм. Тухайн улс хамтын аюулгүй байдал, батлан хамгаалахын ямар нэг эвсэлд нэгдэх, түүний дэмжлэг авах тохиолдолд төвийг сахих, эвсэлд үл нэгдэх статус нь олон улсын эрх зүй, аюулгүй байдлын хувьд хүчин төгөлдөр бус болдог байна. 1907 оноос хойш Төвийг сахих бодлогын талаарх улс төрийн ойлголт, уг бодлогыг амьдралд хэрэгжүүлэх байдал өөрчлөгдөн хувирч ирлээ. Тухайлбал, энэ номонд гарч буй *төвийг сахигч*, улс төрийн хувьд *тодорхой хэмжээнд төвийг сахигч*, *хагас төвийг сахигч* улсууд 1950-аад оноос хойш *НҮБ* хэмээх хамтын аюулгүй байдлын тогтолцооны гишүүд болцгоосон. НҮБ-ын мандатгүй олон улсын эвсэл, холбоодын үйл ажиллагаа, багахан хүрээний цэргийн ажиллагаа зэрэг дайн бүхий тохиолдолд төвийг сахих зарчим үйлчилсэн хэвээр байна.

Аюулгүй байдлын хувьд ижил буюу төстэй орнууд энэхүү төвийг сахих, эвсэлд үл нэгдэх талаар *улс төр, байр суурь, эрх зүйн ялгаатай зарчим баримталж*, *харилцан адилгүй ойлгож, тайлбарлаж* байгааг харуулах, судлан үзэхэд энэ номын зорилго оршиж байна. Ингэхдээ Финлянд, Ирланд, Мальта, Молдав, Австри, Швед, Серб, Украин улсын жишээн дээр авч үзэв.

# 2. Төвийг сахихын учир холбогдол

Төвийг сахих нь тухайн үеийн улс төр, геополитикийн нөхцөл байдлаас хамаарч олон улсын харилцаанд янз бүрээр тайлбарлагдаж байв. Дайны үед аль нэг улс төвийг сахих эсэхээ өөрөө сонгох бөгөөд хэрэв төвийг сахихаар шийдвээс *Хаагийн Конвенцын* 5 дугаар зүйлд заасны дагуу хамгаалагдана. Ингэснээр тухайн улсын нутаг дэвсгэр, агаарын орон зайг гадны цэргийн хүчин ашиглах боломжгүй болж, төвийг сахигч улс дайнд татагдан орохгүй байх ёстой болно. Төвийг сахих зарчим зөвхөн

улс хоорондын зөрчил, маргааны үед хүчин төгөлдөр бөгөөд улс орны дотоод зөрчилд хамаарахгүй юм. Өнөө үед хямрал, зөрчлүүдийн ихэнх нь улс орны дотоодод болж байгаа билээ (Eidgenössisches Departement für auswärtige Angelegenheiten 2014). Төвийг сахихын эрх зүйн үндэс нь *Төвийг сахигч улс, этгээдийн эрх үүргийн талаарх 1907 оны 10 дугаар сарын 18-ны Хаагийн Конвенцын* V (Хуурай газрын дайн), XIII (Тэнгисийн дайн) юм. Төвийг сахих тухай бичгээр зүйлчилсэн эрх зүйн эдгээр заалт олон улсын заншлын эрх зүйн нэг хэсэг болдог (Eidgenössisches Departement für auswärtige Angelegenheiten 2014). Дайтагч хоёр тал, тэдгээрийн хооронд дайнд оролцохоос татгалзагч тал буюу төвийг сахигч *(neuter tertius)* байх тохиолдлыг дээрх хоёр конвенцид тусгажээ. Төвийг сахихыг эрх зүйн  учир холбогдлоор нь дараах хоёр төрөлд хуваан авч үзнэ. Үүнд:

- *Түр зуур төвийг сахих:* Зөвхөн дайны үед хэрэгжинэ. Дайн дуусахтай зэрэгцэн дуусгавар болно.
- *Байнга төвийг сахих:* Төвийг сахигч улс ирээдүйд гарч болзошгүй дайнд оролцохгүй байх, энхийн цагт явуулж буй үйл ажиллагаанаасаа болоод болзошгүй дайнд татагдан орохгүй байх бүх талын арга хэмжээг авах үүрэгтэй. Олон улсын эрх зүйгээр төвийг сахих үүрэг хүлээж болохоос гадна тухайн орон дан улс төрийн үйл ажиллагаагаараа харуулж болно (Fender 2013: 211-ийг үзнэ үү). 1815 оны Венийн конгрессээс хойших Швейцарь улс нь байнга төвийг сахигч орны жишээ юм. Тэр үед Швейцарь улсын төвийг сахих статусыг европын бусад орон хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан юм (Fender 2013: 211-ийг үзнэ үү). Энэ шийдвэрээс хойш байнга төвийг сахих үзэл баримтлал "Олон улсын эрх зүйн хэм хэмжээ болжээ" (Litavski 2012: 1).

Дайн дуусах, дайтагч талуудын аль нэг нь төвийг сахигч оронд халдан довтлох, эсвэл төвийг сахигч өөрөө аль нэг дайтагч талд орвол *түр зуурын төвийг сахих зарчим* дуусгавар болно (Fender 2013: 212-ыг үзнэ үү).

Дээрх хоёр тохиолдлын аль алинд дараах зарчим үйлчилнэ: Төвийг сахих зарчмыг найдвартай сахих, эс тэгвээс бусад улс, түүний дотор дайтагч талд аюулгүй байдлын эрсдэл учруулна. Хамгийн гол нь төвийг сахигч улсын нутаг дэвсгэр халдашгүй байдлаар хангагдана (Eidgenössisches Departement für auswärtige Angelegenheiten 2014-ийг үзнэ үү). Хаагийн V конвенцын 10 дугаар зүйлд зааснаар төвийг сахих статус нь зөрчигдсөнд үзүүлэх хариу нь дайсагнасан үйлдэл

болохгүй (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 45). Дайтагч талуудын нэг нь төвийг сахигчийн статусыг үл хүндэтгэх, нутаг дэвсгэрийг нь хүчлэн ашиглавал тухайн орны төвийг сахих статус хүчингүй болно. Улмаар төвийг сахиж байсан улс өөрийгөө хамгаалах, бусад улстай холбоотны харилцаа тогтоох эрхтэй болно (Fender 2013: 213-ыг үзнэ үү).
Төвийг сахигч дараах үүрэгтэй:

- Нутаг дэвсгэрээ цэргийн зориулалтаар бусдад ашиглуулахгүй байх: "Төвийг сахигч хүчний нутаг дэвсгэр халдашгүй" хэмээн Хаагийн V конвенцын 1 дүгээр зүйлд заажээ (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 44).
- Дайн хийж буй талыг зэр зэвсэг, тоног төхөөрөмж, санхүү, хүн хүчээр дэмжихгүй гэж Австрийн тал үздэг (Fender 2013: 213). Харин Швейцарийн тал "төвийг сахигч улс зэр зэвсэг нийлүүлэх асуудалд дайтагч талуудад адилхан хандана" гэдэг ажээ (Eidgenössisches Departement für auswärtige Angelegenheiten 2014).
- Төвийг сахигчийн нутаг дэвсгэрээр "цэрэг, сум болон хангалтын цуваа дамжин өнгөрөхийг хориглоно" (Хаагийн V конвенцын 2 дугаар зүйл) (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 44).
- Төвийг сахигчийн нутаг дэвсгэрт "дайтагч талуудад зориулсан цэргийн корпус байгуулах, татлагын цэг нээхийг хориглоно" (Хаагийн V конвенцын 4 дүгээр зүйл) (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 44).
- [Хил] давж ирсэн цэргийг хүлээн авсан тохиолдолд тэднийг тусгаарлан байршуулах (Хаагийн V конвенцын 11 дүгээр зүйл) (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 45).
- Дайнд оролцохгүй байх (Хаагийн V конвенцын 17 дугаар зүйл) (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 46).
- Төвийг сахигчийн зүгээс дайтагч талуудад хөлсний цэрэг ч илгээж болохгүй гэж Швейцарийн тал үздэг (Eidgenössisches Departement für auswärtige Angelegenheiten 2014). Хаагийн V конвенцын 6 дугаар зүйлд: "Хүмүүс ганц нэгээрээ хил давж дайтагч талуудад алба хаах явдалд төвийг сахигч улс хариуцлага хүлээхгүй" гэжээ (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 44).

Төвийг сахигч орны хувийн пүүс компаниас дайтагч талуудад зэр зэвсэг,

тоног төхөөрөмж нийлүүлэхийг ерөнхийдөө хориглохгүй байхаар Хаагийн V конвенцын 7 дугаар зүйлд заасан байв:

"Дайтагч талуудад зэвсэг, сум болон явган цэрэг, тэнгисийн цэрэгт шаардлагатай бусад зүйлийг гаргасан, дамжуулсны төлбөрийг саатуулах үүргийг төвийг сахигч улс хүлээхгүй" (Auswärtiges Amt, Deutsches Rotes Kreuz, Bundesministerium der Verteidigung 2006: 44).

Гэсэн хэдий ч энэ заалтын хэрэгжилт бодит байдал дээрээ "хувийн компани зэвсэг экспортлохын тулд төрөөс зөвшөөрөл авдаг дэлхийн ихэнх улсын жишиг"-ийн дагуу өөрчлөгдсөн (Fender 2013: 214).

*Байнга төвийг сахих* нь дайтагч талуудыг ижил гэж үзэхээс үүдэлтэй ба угтаа зорилго нь төвийг сахисан оршин тогтнолоо хадгалахад оршино. Дайн болон төвийг сахих талаарх олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд хүч хэрэглэхийг хориглосон НҮБ-ын үзэл санаа тусгалаа олсон байдаг. Өөрөөр хэлбэл "Дайныг бодлогын хэрэгсэл болгохоос аль болох татгалзах"-аар заажээ (Fender 2013: 218). НҮБ-ын гишүүн бүх орон Аюулгүйн зөвлөлийн шийдвэрийг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд НҮБ-ын дүрмийн 39, 41 болон 42 дугаар зүйлийн дагуу шаардлагатай бүх арга хэмжээнд (улс төр, эдийн засаг, цэргийн хориг) оролцох үүрэгтэй. Хаагийн V дугаар конвенц батлагдах үед *дайн хийх эрх* нь улс төрийн бодлогын хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгсэлд тооцогддог байв. Энэ конвенц хожим шинэчлэгдээгүй ч дайн хийх эрхийн тухай хэсэг нь 1945 онд батлагдсан НҮБ-ын дүрмийн хүч хэрэглэхээс татгалзах үзэл санаанд зайгаа тавьж өгсөн (Fender 2013: 211-ыг үзнэ үү). Улс орнуудын бодит үйл ажиллагаа, практик ялгаанаас үүдэн төвийг сахих эрх зүйн зарчмуудын нэлээд нь тодорхойгүй болж хувирчээ (Fender 2013: 211).

Гэсэн хэдий ч олон улсын харилцаанд төвийг сахигч улсууд байсаар байгаа нь НҮБ-ын тогтолцоо бүрэн төгөлдөршөөгүйг харуулж байна. Швейцарь, Австри зэрэг орны байнга төвийг сахих бодлого нь олон улсын хамтын нийгэмлэг, түүний хамтын аюулгүй байдлын тогтолцоо [төгс] ажилладаггүй гэдэг байр сууринаас үүдэлтэй. Цаашилбал, 2003 онд Америк, Англи тэргүүтэй улсууд Саддам Хуссейний дэглэмийг унагасан зэрэг олон тохиолдолд хэрэглэсэн урьдчилан сэргийлэх батлан хамгаалах *(präventiven Verteidigung)*, сөрсөн батлан хамгаалах *(präemptiven Verteidigung)* үйл ажиллагаанууд нь НҮБ-ын тогтолцоо явж явж тухайн гишүүн орнуудын ашиг сонирхлоос хамааралтай байгааг харуулсан. Европын холбоо аюулгүй байдлын эвслийн шинж агуулж, НҮБ олон улсын байгууллага хамтын аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлж байгаа нь Ирланд, Мальта, Австри зэрэг төвийг сахигч улсууд, Финлянд, Швед зэрэг эвсэлд үл нэгдэгч орнуудад

улам бүр сорилт болж байна. Учир нь эдгээр улс төвийг сахих, эвсэлд үл нэгдэх зарчмаа Европын холбоо, НАТО зэрэг байгууллагын цэргийн ажиллагаатай уялдуулах шаардлага гарч байна.

# 3. Төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч орнуудад учрах аюул занал

2014 онд Европын холбооны гишүүн орнууд аюулгүй байдлын томоохон сорилтуудтай тулгарахад төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч орнуудын зүгээс тусалж дэмжиж бараг чадсангүй: Донецк, Луганск мужийн салан тусгаарлах оролдлоготой холбоотой Украины дотоодод зэвсэгт мөргөлдөөн болж, 2014 оны 3 дугаар сард Крым Украины бүрэлдэхүүнээс гарч[1] ОХУ-д хүчээр нэгдэв; Сири улсын задрал[2] хурцадсан бөгөөд “цаашид асуудал шийдэгдэх найдлага харагдахгүй байна” (Müller 2014: 6); Ирак, Сирийг дамнасан Исламын улс бүлэглэл[3] Иракийг ч задралд хүргэв; Иракийн нутаг дэвсгэрт, тухайлбал Курдистаны автономит мужийн нутагт Исламын улс бүлэглэлийн явуулсан байлдааны улмаас олон мянган хүн дүрвэж, шашны цөөнхийг[4] алан хядах ажиллагаа

1 ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Крымийн хойгт (цус асгаруулалгүй) хийсэн цэргийн ажиллагаагаа орос хүмүүсийг аварсан явдал гэж тодорхойлсон. “Гарал үүслийн хувьд орос биш боловч өөрсдийгөө Орос ертөнцийн нэг хэсэг гэж үзэж буй хүмүүст” хүртэл энэ байдлаар тусалж болно гэдгээ В.Путин мэдэгдсэн юм. Эдгээр хүмүүст ОХУ-ын зүгээс “улс төр, эдийн засгийн арга хэрэгсэл, цаашилбал өөрийгөө хамгаалах эрхийн талаарх олон улсын хүмүүнлэгийн ажиллагааны эрх зүйн хүрээнд” туслахаа илэрхийлсэн. 2014 оны 6 дугаар сарын 1-нд шаардлагын хугацаа дуусаж, яриа хэлэлцээ амжилтгүй боллоо хэмээн Украины Ерөнхийлөгч Петр Порошенко гал зогсоосон шийдвэрээ цуцалж “Бид довтолж, нутгаа чөлөөлөх болно” гэв (Sommerbauer 2014: 1).

2 Босогчдын бүлэглэлүүд хоорондоо болон Башар ал-Ассадын эсрэг 3 жил орчим тэмцэлдсэнээс болж олон мянган хүн дүрвэж буй нь хөрш орнуудад ихээхэн бэрхшээл учруулж байна: 2014 оны 3 сар гэхэд Ливан, Ирак, Йордан, Египет, Турк улс руу 2,5 сая хүн аюулаас зугтан дүрвээд байгаа нь Ойрх Дорнодын шинэ үеийн түүхэнд байгаагүй гамшиг юм (Gehlen 2014: 5-ыг үзнэ үү).

3 *ISIS* нь угтаа Ирак дахь Аль Кайдагаас үүсэлтэй: Эдгээр исламын дайчин 2012 оноос хойш Абу Бакр ал Багдади-гийн удирдлага дор янз бүрийн эвсэл холбоо байгуулан, улмаар Сирийн хойд хэсэг дэх Ал-Ракка орчмыг мэдэлдээ авчээ. 2013 оны 5 дугаар сарын сүүлээс Иракаас Ливан хүртэлх нутагт олон хэсэг газрыг холбон байлдааны ажиллагаа явуулж, Ирак Левантын исламын улс *(ISIL)* гэгчийг зарлажээ. 2014 онд тэд Америкийн эсрэг иракийн тэмцэгчдийн цайз болсон Фалуджад бэхжиж авчээ. 2014 оны 6 дугаар сараас тэд Иракийн төв рүү дайрч эхлэв. Саддамын хамсаатан асан, Суннит урсгалын овгийн толгойлогчийн дэмжлэгтэйгээр тэд Моссулыг нүд ирмэх зуур эзлэв. *ISIL*- ийнхэн иракийн цэргийн шинэхэн зэвсгийн агуулахыг түйвээн эзлэхэд иракийн цэргийн зарим нь ум хумгүй зугтаж, зарим нь бууж өгчээ (vgl. Der Soldat 2014: 2).

4 2014 оны 6 дугаар сараас хойш Иракийн хоёр дахь том хот Моссулд христийн шашинтан үлдээгүй. *ISIS* –ын удирдагчид 1800 жил Мосулд амьдарч ирсэн христийн шашинтнуудыг нэг бол 2014 оны 6 сарын 19-ний дотор Моссулыг орхин явах, эсвэл исламын шашинд орж, тусгай татвар төлөхийг шаарджээ. “Шаардлагыг дагахгүй бол илдийн хүчээр зохих шийтгэлийг хүртээнэ” хэмээн исламын дайчдаас тараасан ухуулах хуудаст бичсэн байлаа. 2014 оны 6 сарын 19, 20-ны өдрүүдэд ойролцоогоор 25,000

явуулсан; 2011 оны 10 дугаар сард Муаммар Ал-Гаддафиг түлхэн унагасны дараа Ливи улс[5] задарсан; Газын зурваст Израил, Хамасын зөрчил дахин сэдэрч, дайны хэмжээнд хүрсэн. Түүнчлэн Хойд Африкаас дүрвэгчдийн урсгал Европ руу цувж байна. *Мали, Төв Африкийн бүгд найрамдах улс, Сомалийн хойг* зэрэг газарт зарим улс, Европын холбоо, олон улсын байгууллагууд хамтран байдлыг тогтворжуулахаар чармайж байна.

Европын холбооны төвийг сахисан, эвсэлд үл нэгдэгч орнуудын аюулгүй байдлын бодлогод *аюул заналын* тухай ойлголт төстэй буюу ижил байна. Австрийн хувьд аюул занал нь: олон улсын терроризм, үй олноор хөнөөх зэвсгийн тархалт, улс орнуудын дотоодын болон бүс нутгийн зөрчил, түүний нөлөө, төрт улсуудын доройтол, байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, кибер халдлага, стратегийн дэд бүтцүүдэд учирч буй занал, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхины худалдаа, авлига, хууль бус цагаачлал, бүтэлгүй интеграц, баялгийн хомсдол (эрчим хүч, хоол хүнс, ус), цаг уурын өөрчлөлт, байгаль орчны сүйдэл, халдварт өвчин, далайн дээрэм, худалдаа, тээврийн замд гарч буй эрсдэлүүд болон олон улсын санхүү, эдийн засгийн хямралын үр дагавар зэрэг орж байна. Ялангуяа кибер халдлагаас хамгаалах нь Австрийн хувьд төрийн үүрэг бөгөөд энэ талаар австрийн жанжин штабын командлагч Отмар Коммендa *(Othmar Commenda)*-гийн тодорхойлсноор “олон асуудлын зангилаа шинжтэй” юм (Commenda 2014: 5). Кибер аюулгүй байдлыг хангах нь *Холбооны Батлан хамгаалах, спортын яам, Холбооны дотоод хэргийн яам, Канцлерын тамгын газрын* аль алинд хамаарна. Нийт улс орон даяарх зохицуулалтыг Канцлерын тамгын газар хариуцдаг бол кибер гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг Холбооны дотоод хэргийн яам, кибер аюулаас хамгаалах ажлыг Батлан хамгаалах, спортын яамны чиг үүрэгт хамаарна. 2011 онд Австри улс дээрх чиглэлийг тусгайлан хариуцах

---

христийн шашинтан Моссулыг орхисон байна. Тулган шаардлагын хугацаа дуусахаас өмнө *ISIS*-чүүд хотоор явж, христийн шашинтнуудын байшин дээр “N” тэмдэг тавьж байв (Коран судart христийн шашинтнуудыг *Nassarah* гэсэн байдаг). *ISIS*-чүүд мөн Есид *(Jesiden),* Шабак *(Schabak)* болон Туркмен зэрэг шашины цөөнхүүдийг мөрдөн хавчиж, хөөсөн юм. Тэдгээрийн байшин дээр “R“ гэсэн тэмдэг тавьж байсан нь *Rafidha* буюу “эсэргүү” гэсэн утгатай гэнэ. 2003 онд Саддам Хуссейны дэглэм унаснаас хойш исламын террорист бүлэглэлүүдийн үйл ажиллагаанаас үүдэн 600,000 христийн шашинтан Иракийг орхин гарчээ (Wrase 2014: 6).

5 Арабын ертөнцөд Ливи улсыг Египеттэй харьцуулахад нөгөө туйл нь юм: Ливид төрт улсын уламжлал байсангүй, харин овог, отгийн зохион байгуулалттай бөгөөд Муаммар ал-Гаддафигаас хойш энэ байдал улам ч тодорсон юм. Тус улсын нутаг дэвсгэр хоорондоо эрс ялгаа бүхий 3 хэсэгт хуваагддаг бөгөөд эдгээрийг нийлүүлж XX зуунд улс болгоод байлаа (Müller: 2014: 6).

нэгж *Цэргийн мэдээллийн технологийн шуурхай бэлэн байдлын баг (mil-CERT military Computer Emergency Readiness Team)*-ийг байгуулсан бөгөөд энэ нь олон улсын сургуулилтын үеэр үр дүнгээ харуулжээ (Commenda 2014: 5).

2003 оны 12 дугаар сарын 12-нд Европын холбооны бүх гишүүн улс, түүний дотор төвийг сахигч, эвсэл үл нэгдэгч Финлянд, Ирланд, Австри, Швед улс хамтран Европын зөвлөлийн шугамаар анхны бөгөөд эдүгээ хүртэл ганцхан байгаа Европын аюулгүй байдлын стратеги *(ESS)*-г баталжээ. Энэхүү баримт бичигт Европын холбоонд тулгарах аюул эрсдэл, сорилтуудыг санал нэгдэн тодорхойлсон юм. Европын аюулгүй байдлын стратегийн эхний хэсэгт эдүгээ дэлхий дахинд тулгарч буй сорилтуудыг авч үзээд, эдгээрээс голлох таван сорилтыг тодорхойлжээ:

- "Терроризм бол Европыг бүхэлд нь хамарч буй "стратегийн аюул занал (Европын холбоо 2003: 3). Сүүлийн үед гарч буй террорист ажиллагаанууд ихэнхдээ шашны суурь үзлээс үүдэлтэй байна. "Европ тив нэг талаас террорист ажиллагааны бай, нөгөө талаас террористуудын түшиц газар болж байна. Европын орнууд террорист халдлагын бай болж байсан, одоо ч тийм байна. [...] Иймээс Европын орнууд энэ аюулын эсрэг хамтаар тэмцэхээс өөр арга зам үгүй юм" (Европын холбоо 2003: 3). Сири, Иракийн задралын жишээнээс харахад исламын бүлэглэлүүд террорист ажиллагаатай холбоотой нь тодорхой байна. Салафист, вахабист суртал жихадын зэвсэгт дайчдаар дэмжүүлж буй бөгөөд ялангуяа 2011 оноос эхтэй Арабын хавар, Исламын улсын хүчирхэгжилтээр хүч нэмэн дэлгэрлээ. Европын холбоо, Америк, ОХУ-ын олон зуун залуу жихад зэвсэгт бүлэглэлд нэгдэж орсон, одоо ч нэмж орсоор байна (Alvi 2014: 38–50-ыг үзнэ үү). Эдгээр залуус эргэн ирэхдээ Европт ч зөрчил үүсгэнэ хэмээн европын аюулгүй байдлын албад болгоомжилж байна. 2014 онд Франц, Герман улс зэвсэгт бүлэглэлийн гишүүн байж болзошгүй исламын шашинтнуудыг нэвтрүүлэхгүй байх талаар улс төрийн түвшинд ярилцсан бол Испаничууд исламын бүлэглэлийн гишүүд эргэн ирэх нь үндэсний аюулгүй байдалд томоохон аюул учруулна гэж үзэв. Исламын бүлэглэлийн гишүүд Их Британи руу нэвтрэх гэж байгаад баригдах нь элбэг байгаа бөгөөд 300 гаруй нь Их Британид эргэн ирээд байгаа мэдээ бий. Австрид ч 100 гаруй дайчин эргэн ирэх магадлалтай талаар зовниж байна (Salzburger Nachrichten 2014a: 1 –ийг үзнэ үү). АК-47 буугаа хэрхэн ид хав болгож буй, хүн цаазалж буйг үзүүлсэн балмад бичлэг, фото зургаа интернетийн сүлжээ ашиглан тарааснаар *жихад* нь төвийг сахисан, эвсэлд үл

нэгдэгч орнуудад ч хүрээд байна. "Кино, компьютер тоглоомын адил иймэрхүү зураг, бичлэгүүд хүчирхийллийг хөхиүлэн өдөөдөг. Үйл явдлыг театрчилан дүрсэлж, дуу, хөгжим оруулан амилуулснаар дотор нь орсон мэт сэтгэгдэл төрүүлж байгаа нь залуусын сонирхлыг татдаг ажээ" (Salzburger Nachrichten 2014b: 3).

- Үйл олноор хөнөөх зэвсэг, түүнийг тээвэрлэх систем нь "аюулгүй байдалд учирч болзошгүй хамгийн том заналхийлэл" юм (Европын холбоо 2003:3). Террорист бүлэглэлүүд ямар нэг байдлаар "үй олноор хөнөөх зэвсэгтэй болж болзошгүй. Хэрэв ингэвэл ямарч жижиг бүлэглэл бүхэл бүтэн улс, зэвсэгт хүчнээс дутуугүй их хор хөнөөл учруулах боломжтой болно (Европын холбоо 2003:4).
- Бүс нутгийн хямрал зөрчил нь экстримизм, терроризм, цаашилбал улс орны сүйрэлд хүргэж болзошгүй. Түүнчлэн зохион байгуулалттай гэмт хэрэг цэцэглэх хөрс болно (Европын холбоо 2003:4).
- Улс орны сүйрэл *(failed states):* Авлига, эрх мэдлийг буруугаар ашиглах, сул дорой институц, хариуцлагын тогтолцооны дутмаг байдал, иргэдийн зөрчил тэмцэл зэргээр илрэх засаглалын доройтол улс орныг дотроос нь сүйтгэдэг (Европын холбоо 2003:4).
- Террорист бүлэглэлүүдтэй холбоотой мансууруулах бодис, хүний наймаа, эмэгтэйчүүдийг худалдаалах явдал, зэвсгийн наймаа зэрэг хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг: "хүч хэрэглэхээс огтхон ч буцахгүй террористууд, үй олноор хөнөөх зэвсэгтэй болох, зохион байгуулалттай гэмт хэрэг, төрийн тогтолцоо суларч, эрх мэдэл хувь хүнд төвлөрөх зэрэг олон зүйлийн нийлбэр нь Европт маш ноцтой заналхийлэл болж болзошгүй (Европын холбоо 2003:5).

Европын аюулгүй байдлын стратегийг хэрэгжүүлэх тухай баримт бичигт 2008 онд кибер аюулгүй байдал, эрчим хүчний аюулгүй байдалд учирч болох сорилтуудыг нэмж оруулсан билээ. Тэнд дурдсанаар Европын холбоонд дараах 5 гол аюул заналхийлж байна: Үй олноор хөнөөх зэвсгийн тархалт, терроризм болон зохион байгуулалттай гэмт хэрэг, интернет орчны аюул, эрчим хүчний аюулгүй байдал болон цаг уурын өөрчлөлт (Европын холбоо 2003:3-аас хойш үзнэ үү).

Энэ бүхнээс үүдэн сүүлийн 20 жилд Европын төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч орнууд дээрх аюул заналын эсрэг иргэний болон цэргийн түвшинд нягт хамтарч сөрөн зогсохоо илэрхийлж ирлээ. Үүний нэг илрэл нь гуравдагч орны цагдаа, цэргийн албан хаагчдыг нутагт нь сурган, аюул эрсдэлтэй бие даан тэмцэх чадвартай болгож буй явдал юм. Энэхүү *гадаад орон дахь ажиллагаа* энхийг сахиулах, улс орон, бүс нутгийг тогтворжуулахад чухал хувь нэмэр болох учиртай. Австрийн

хувьд *гадаад дахь ажиллагаа* нь тус улсад өөрт нь нөлөөлөх байдал, европын эв нэгдлийг хангах хүрээнд Европын холбоонд ач холбогдолтой эсэх, дэлхий дахины аюулгүй байдлыг хангах хүрээнд НҮБ-д ач холбогдолтой эсэх, түүнчлэн Австри улсын эдгээр байгууллагад эзлэх байр суурь зэргээс хамаарна.

Европын холбоо Аюулгүй байдлын стратегиараа дамжуулан олон улсын эрх зүйн хүрээнд олон талт тогтолцоог бэхжүүлэх – үр нөлөөтэй олон талт тогтолцоо бий болгохоор чармайж байна. “Бидний зорилт бол дэлхийн хамтын нийгэмлэгийг бэхжүүлэх, олон улсын институцуудын үйл ажиллагааг сайжруулах, сайтар зохицуулалт бүхий дэлхийн дэг журмыг цогцлоох юм” (Европын холбоо 2003:9). Энэ утгаараа Европын холбоо “олон улсын эрх зүйг сахих, цааш хөгжүүлэх үүрэгтэй. НҮБ-ын дүрэм олон улсын харилцааг зохицуулах үндсэн хүрээ нь болно”. Тиймээс “дэлхий дахинд энх тайван, олон улсын аюулгүй байдлыг хангах гол үүрэг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд ногдож байна.” НҮБ-ыг бэхжүүлэх болон “түүнийг оногдсон үүргээ биелүүлэх, үр нөлөөтэй ажиллах арга хэрэгслээр хангах нь Европын хувьд нэн тэргүүний зорилт юм” (Европын холбоо 2003:9).

Гэсэн хэдий ч Европын аюулгүй байдлын стратегид ямар нэг амин чухал ашиг сонирхлыг Европын холбооны хэмжээнд гаргаж тавьсангүй. Энэ байдлаас болж дээр дурдсан аюул занал, сорилтуудыг эрэмбэлэх, зөрчилт бүс нутгуудад Европын холбооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход бэрхшээлтэй тулгарчээ. Түүнчлэн Европын холбооны хямралыг зохицуулагч болон асуудалтай орны хооронд даалгаварт ажиллагааны зорилгоос үүдсэн үзэл бодлын зөрүү байнга гардаг. Үүний тод жишээ нь *Гвиней-Бисау*-гийн аюулгүй байдлын салбарт шинэчлэл хийх гэсэн Европын холбооны ажиллагаа билээ. Аюулгүй байдлын салбарт нь шинэчлэл хийснээр тус улсыг тогтворжуулж, эрх зүйт төрийг бэхжүүлж, нийгэм эдийн засгийн тайван хөгжлийг нь дэмжинэ хэмээн олон улсын хандивлагчид нь (Европын холбоо*, Португал хэлт улсуудын холбоо- CPLP*, АНУ, Бразил, НҮБ-ын Энхийг цогцлоох сан) найдаж байлаа (Kohl 2013: 5-ыг үзнэ үү). Европын холбооны уг ажиллагаа 2010 онд бүтэлгүйтсэн бол 2012 оны 4 дүгээр сард болсон төрийн эргэлтийн улмаас олон улсын хамтын нийгэмлэгийн ихэнх төсөл зогсжээ. Аюулгүй байдлын салбарт шинэчлэл хийх төлөвлөгөө нь “одоогийн энэ байдлаараа хэрэгжих боломжгүй. Учир нь хэрэгжүүлэгч, хүлээн авагч талын хооронд шинэчлэл, түүний үр дүнгийн талаар тэс ондоо төсөөлөлтэй байгаа бөгөөд тухайн газрын багахан ашиг сонирхол, болзол төдий ойлгогдож байгаа юм” (Kohl 2013: 1). Байдал тогтворгүй байгаа Бүгд Найрамдах Ардчилсан Конгод

Европын холбооноос явуулсан багахан ажиллагаанд тус холбооны нэгдмэл стратеги дутагдсан дараагийн нэгэн жишээ байна. Энд Европын холбоо гол хэрэгжүүлэгч бөгөөд тус улсад хоёр ч удаа (2003 болон 2006 онд) цэргийн ажиллагаа явуулж, одоогийн байдлаар цагдаа, зэвсэгт хүчний салбарт шинэчлэл хийх хоёр ажиллагаа хэрэгжүүлж байгаа билээ. Гэсэн ч европчууд БНАКУ-ын ирээдүйг [эерэгээр] тодорхойлж чадахгүй байна.

Европын холбоо *Мали, Сомали* улсад багахан хэмжээний сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа *бол Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад* байдлыг тогтворжуулах, *Нигерт* цагдаа, хуулийн байгууллагынхны чадавхыг бэхжүүлэх*, Сомалийн хойгт* терроризм, далайн дээрэмтэй тэмцэх ажиллагаа явуулж байгаа. Сири, Ирак, Ойрх Дорнод дахь зэвсэгт мөргөлдөөн, Ливи дэх отог омгийн зөрчил, Мали, Сомали, Өмнөд Судан дахь нэн тогтворгүй байдлаас болж олон олон африкчууд Европын холбоог зорих болов: Өмнөд Европ Африк, Ойрх Дорнодоос ирж буй дүрвэгчдийн цуваанд дарагдаад байна. 2000-аас 2014 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд Европыг зорьсон цагаачдаас 23000 хүн амь насаа алдсан, сураггүй алга болсон байна[6]. 2014 оны 8 дугаар сард гэхэд 800,000 дүрвэгч Ливи улсаас Европ руу явахаар хүлээж байна гэж Италийн Дотоод хэргийн яам мэдээллээ (Gabriel 2014a: 4-ийг үзнэ үү). 2014 оны 1 дүгээр сараас 8 дугаар сарын хооронд 100,000 орчим дүрвэгч завиар Италид хүрч иржээ (Laczynski 2014b: 1-ийг үзнэ үү). 2013 оны 12 дугаар сарын 11-нд *Европын Комисс болон Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн дээд төлөөлөгчийн* гаргасан мэдэгдэлд дэлхий дахины сорилт улам бүр нэмэгдэхийн зэрэгцээ ээдрээтэй болж буйг цохон тэмдэглэжээ: Цаг уурын өөрчлөлт, байгалийн баялагийн хомсдол, хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөний урсгал, хууль бус худалдаа, эрчим хүчний хангамжийн аюулгүй байдал, байгалийн гамшиг, кибер аюул, далайн замын аюулгүй байдал, бүс нутгийн зөрчил, хэт радикал үзэл, терроризм гэх мэт. “Салангид явуулж буй цэргийн ажиллагаагаар хямралт бүс нутгуудыг удаан хугацаанд тогтвортой байлгах боломжгүй” (Lattacher 2014: 4). Хямралыг цэргийн аргаар зохицуулахдаа “аюулгүй

6 Европын 10 сэтгүүлчийн санаачилсан The Migrants Files төслийн мэдээнд ийнхүү дурджээ. Энд нийтлэгдсэн мэдээллийг тэд Ашгийн бус байгууллагууд, албаны эх сурвалжид үндэслэн боловсруулж, анализ хийн мэдээллийн багц болгон нэгтгэжээ. 2014 оны 1 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд Өмнөд Италид ирж буй цагаачдын тоо 2013 онтой харьцуулахад 500-гаас 5475 болж 10 дахин өсжээ. 2013 оны 10 дугаар сард Лампедуса арлын орчим завьтай дүрвэгчдээс 360 хүн живж үхжээ. Италийн эргийн харуул бусад улстай хамтран завьтай дүрвэгчдийг ослоос сэргийлэх Mare Nostrum ажиллагаа явуулж эхэлжээ (Gabriel: 2014b: 5-ыг үзнэ үү).

байдал болон хөгжлийн асуудалд цогцоор нь хандах хэрэгтэй. Аль аль салбарт урт хугацаанд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь шийдвэрлэх ач холбогдолтой” (Lattacher 2014: 4).

## 4. Туслан дэмжих үүрэг, эвсэлд үл нэгдэх болон төвийг сахих

Нэмэлт өөрчлөлт оруулсан  Европын холбооны тухай гэрээ (Лиссабоны гэрээгээр баталсан Европын холбооны гэрээ)-ний 42 (7) дугаар зүйлд туслан дэмжих үүргийн талаар дараах байдлаар тусгажээ:

“Аль нэг гишүүн орны нутаг дэвсгэр зэвсэгт халдлагад өртсөн тохиолдолд бусад гишүүн орнууд НҮБ-ын дүрмийн 51 дүгээр зүйлтэй уялдуулан өөрийн бүхий л эрх, хэмжээний хүрээнд туслан дэмжих үүрэгтэй. Энэ заалт нь тодорхой гишүүн орнуудын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын онцлог чанарыг хөндөхгүй. Аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт [ЕХ-ны] гишүүн орнуудын үүрэг хариуцлага, хамтын ажиллагаа нь Умард Атлантын гэрээний байгууллагын хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагатай уялдана. Умард Атлантын гэрээний байгууллагын гишүүд уг байгууллагын хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны суурь, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл гэж үздэг. (Lenz/Borchardt 2008: 72).

Үүнээс үзвэл Европын холбооны гишүүн орнууд ямар байдлаар туслан дэмжих, [НАТО-гийн] гэрээний бус Европын холбооны гишүүн орнуудад тусламж үзүүлэх эсэхээ өөрсдөө шийдэхээр байна:

“Аль нэг гишүүн орны нутаг дэвсгэр зэвсэгт халдлагад өртсөн тохиолдолд бүх гишүүн орон өөрийн бүхий л эрх, хэмжээний хүрээнд туслан дэмжих тухай заалт нь Лиссабоны гэрээнд орсон хамгийн чухал өөрчлөлтүүдийн нэг юм. Гишүүн орнууд цэргийн тал дээр ч хувь заяагаараа нэгдэж байгаа хэрэг. Энэ заалт хэрхэн үйлчлэхийг төвийг сахигч орнууд өөрсдөө шийдвэрлэх юм. (Lenz/Borchardt 2008: 27). (Fender 2013: 219f.).

Угтаа бол Европын холбооны гишүүн бүр “тус холбооны аль нэг гишүүн улс халдлагад өртвөл, өөрийгөө хамгаалах эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь түүний зөвшөөрлийн үндсэн дээр туслан дэмжих үүрэгтэй” (Fender 2013: 219). “Энэ заалт нь тодорхой гишүүн орнуудын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын онцлог чанарыг хөндөхгүй” гэсэн нь байнга төвийг сахигч орнуудыг уг үүргээс тусгайлан үзсэн явдал хэмээн Австри, Ирланд зэрэг төвийг сахигчид үздэг. 1991 онд *Европын холбооны талаарх Маастрихтын* гэрээг хэлэлцэж байх үед Ирланд улс дээрх заалтыг оруулахаар “зүтгэж” байсан тул *Ирландын заалт* хэмээн нэрлэх болсон билээ (Fender 2013: 220). Австри улсын хувьд туслан дэмжих тухай ЕХ-ны гэрээний 42 (7) дугаар заалт нь “аль нэг гишүүнд учрах цэргийн түрэмгийллийн тухайд магадлал багатай. [...] Австрийн зүгээс цэргийн дэмжлэг үзүүлэх илүү тодорхой нөхцөл нь Европын холбооны аль нэг гишүүнд гадны,

өөр улсын зохион байгуулалттай түрэмгийлэл гарах явдал юм. Энэ тохиолдолд “Ирландын заалт”-ыг хэрэглэх нь эрх зүйн хувьд нээлттэй, гэхдээ үүрэг хүлээх байдал автоматаар үүсэхгүй. “Ирландын заалт” нь аль нэг улсад цэргийн тусламж үзүүлэх эсэх, хэрхэн туслах зэргийг өөрөө шийдэх эрх олгож байна гэж Австри үздэг” (Frank 2013: 197). Туслахаар болсон тохиолдолд “одоогийн Үндсэн хуулийн дагуу НҮБ-ын мандат зайлшгүй шаардлагатай юм” (vgl. Frank 2013:197). Угтаа бол Австри улс “болзошгүй тохиолдолд тусламж үзүүлэх тухай европын холбооны эрх зүйн заалтыг дагах үүрэггүй. Европын холбооны Аюулгүй байдал, батлан хамгаалахын нэгдсэн бодлого *(GSVP)*-д европыг хамтдаа батлан хамгаалах талаар тусгагдаагүй, энэ талаар Европын зөвлөл санал нэгдэж шийдвэрлэдгийг харгалзан үзэх учиртай” (Bundesministerium für Landesverteidigung und Sport/Bundesministerium für Inneres 2013: 38f.).

Ирландын ард түмэн санал асуулгын үндсэн дээр зөвшөөрөөгүй л бол тус улс ЕХ-ны гэрээний 42 (7) дугаарт заасан Европын холбооны батлан хамгаалах үйл ажиллагаанд оролцохгүй:

„Ирландын ард түмэн санал асуулгын үндсэн дээр зөвшөөрөөгүй л бол тус улс ЕХ-ны гэрээний 42 (7) дугаарт заасан Европын холбооны батлан хамгаалах үйл ажиллагаанд оролцохгүй. Тус улсын засгийн газар энэ шаардлагаа өөрчлөхийг зорихгүй байгаагаа тодорхой илэрхийлсэн“ (McBean 2005: 26).

Энэ жишгээр бол Европын холбоо хэзээ ч батлан хамгаалах үндсэн хэлбэр болохгүй гэдгийг Финляндын Батлан хамгаалахын сайд Карл Хаглунд *(Carl Haglund)* 2014 оны нэгдүгээр сард Вашингтонд айлчлах үеэрээ онцлон тэмдэглэв (vgl. Benitez 2014).

*Лиссабоны гэрээний 42 (2) дугаарт* Европын холбоо хамтын батлан хамгаалах үйл ажиллагаа явуулах зорилгоор батлан хамгаалах нэгдмэл бодлогоо алхам алхмаар тодорхойлохоор заасан. Европын зөвлөлд төр засгийн тэргүүнүүд энэ талаар санал нэгтэй батлах ёстой. Франц улсын хувьд Европын холбооны батлан хамгаалах нэгдсэн бодлогыг улам бэхжүүлэх ёстой бөгөөд төвийг сахих нь үүнд бэрхшээл учруулж буй юм. Тэдний үзэж буйгаар Европын холбооны батлан хамгаалах бодлого европ тивийг хамгаалагч хэрэм болсон НАТО-г бэхжүүлэхэд чиглэх ёстой:

„Европт бид батлан хамгаалах бодлогыг нэгтгэж, улам хүчтэй болгох ёстой. Төвийг сахих нь XXI зуунд аюулгүй байдлаа хангах хангалттай хэрэгсэл биш, Нэгдсэн аюулгүй байдал, батлан хамгаалах хүчтэй бодлоготой байснаар НАТО-г бэхжүүлнэ“[7].

7 Европын батлан хамгаалах агентлаг (EVA)-ийн гүйцэтгэх захирал Claude- France Arnould 2012 оны 12 дугаар сарын 17-нд Вена хотын Аж үйлдвэрийн ордонд ажлын

# 5. Эв нэгдлийн заалт

Европын холбооны гишүүн орнууд цэргийн болон иргэний бүх арга хэрэгслээ дайчлан холбооны нутаг дэвсгэрт террорист аюул заналаас хамгаалахад *Эв нэгдлийн заалт* зориулагджээ. *Европын холбооны үйл ажиллагааны тухай гэрээний 222 дугаар зүйлд* энэхүү *Эв нэгдлийн заалт* (терроризм, гамшгийн үед дэх эв нэгдэл) дараах байдлаар тусгагджээ:

"Аль нэг гишүүн улсад террорист халдлага, байгаль болон хүнээс үүдэлтэй гамшиг нүүрлэвэл Европын холбоо, түүний гишүүд эв нэгдлийн үзэл санаан дор хамтарч үйл ажиллагаа явуулна. Европын холбоо дараах зорилгоор өөрийн бүх нөөц бололцоо, түүний дотор гишүүн улсуудаас гаргаж өгсөн цэргийн арга хэрэгслийг дайчлан ажиллана:

a) Гишүүн орны нутагт терроризмын аюул заналыг няцаах; болзошгүй террорист халдлагаас ардчилсан институц, ард иргэдийг хамгаалах; террорист халдлагад өртсөн гишүүн орныг түүний [төр, засгийн] байгууллагын хүсэлтэд үндэслэн нутаг дэвсгэр дээр нь тусалж дэмжих;
b) байгаль болон хүнээс үүдэлтэй гамшиг нүүрлэсэн гишүүн орныг түүний [төр, засгийн] байгууллагын хүсэлтэд үндэслэн нутаг дэвсгэр дээр нь тусалж дэмжих;

Ийнхүү террорист халдлага мэтийн аюул учирсан даруйд тухайн улстай *эв нэгдэлтэй хамтран ажиллахыг* гишүүн улсууддаа уриалжээ. [Европын холбооны] зөвлөл нь Европын Холбооны комисс болон Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудал хариуцсан дээд төлөөлөгчийн хамтарсан саналыг үндэслэн, 222 дугаар зүйлд заасны дагуу тухайн улсад шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргана. Австрийн талын үзэж буйгаар *Европын холбооны үйл ажиллагааны тухай гэрээний 222 дугаар зүйл* нь төвийг сахихтай харшлахгүй. "Учир нь дурдагдсан бүх тохиолдол нь дайнд хамаарахгүй тул төвийг сахих эрх зүйн үндэст нөлөөлөхгүй" (Fender 2013: 220) юм. *Эв нэгдлийг үүрэг болгосон* энэхүү 222 дугаар зүйлийн заалт "Европын холбооны бүх гишүүн улсад хамаатай. Иймээс Австрийн хувьд ч төвийг сахих талаар эрх зүйн ямар нэг болзол тавигдахгүй. […] Өнөөгийн нөхцөл байдлаас харахад эв нэгдлийн үүргийг бодитоор биелүүлэхэд НҮБ-ийн мандат шаардлагатай (Frank 2013: 196). Ирландын хувьд үүнийг дараах байдлаар авч үзэж байна:

айлчлал хийх үеэрээ мэдэгдсэн. Доктор Гүнтер Хаусерын тэмдэглэл.

„[...] Эв нэгдлийн талаарх үүргээ хэрхэн биелүүлэхдээ гишүүн улс бүр хамгийн зохистой аргыг сонгох бөгөөд энэ зарчмын дагуу Ирланд улс уламжлалт бодлогоо харгалзан үзэж, хариу үйлдлээ тодорхойлно“ (McBean 2005: 26).

Шведийн хувьд ч эв нэгдлийн талаарх 222 дугаар зүйлийн нөхцөлд хэрхэн хандахыг дотоодоо шийдвэрлэх ажээ: „Бид хамгийн зохистой гэсэн хэлбэрээр хувь нэмрээ оруулна“ (Bjurner 2005: 40).

# 6. Австри улсын төвийг сахих бодлого

Австри улс, Зөвлөлт Холбоот улсын хооронд 1955 оны 4 дүгээр сарын 15-нд баталсан *Москвагийн Меморандумын* дагуу "Австри улс нь Швейцарь улсын хэрэгжүүлж буй төвийг сахих бодлоготой адил бодлого хэрэгжүүлэх" үүрэг хүлээжээ. Гэхдээ энэ нь "Швейцарийн загварыг сохроор дагана гэсэн үг биш юм" (Kaminski 1974: 9). Энэхүү меморандум нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээ биш бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйч Алфред Вердросс *(Alfred Verdross)*- ын хэлсэнчлэн "энэхүү баримт бичиг нь Австри улсын байнга төвийг сахих бодлогыг ойлгоход тустай" юм (Kamisnki 1974:10-ыг үзнэ үү). Австри улсын *Байнгын төвийг сахих бодлогыг* бусад улсууд тулгасан мэт харагддагаас Австри улсын тусгаар тогтнолын гэрээнд тусгагдаагүй (Бельведер харш, 1955 оны 5 дугаар сарын 15). Австри улс "Швейцарийн жишээгээр" байнга төвийг сахих бодлого хэрэгжүүлж, үүндээ бүх дотоод бололцоогоо ашиглана гэсэн нөхцлөөр Зөвлөлт холбоот улс Австрийн Тусгаар тогтнох гэрээг батлахаар болсон. "Үүнээс үзэхэд Байнга төвийг сахих бодлого болон Австри улсын тусгаар тогтнох гэрээ хоёрын хооронд улс төр, түүхийн учир холбогдол байгаагаас бус эрх зүйн хувьд хамааралгүй юм" (Stolzlechner 2013:79). Иймд, Австри улсын *Байнга төвийг сахих* бодлогыг зохицуулахын тулд Төвийг сахих тухай хууль баталжээ (1955 оны 10 дугаар сарын 26-ны Холбооны Үндсэн хууль, BGBl. Nr. 211, Австри улсын төвийг сахих бодлогын талаар). Үүнд:

1 дүгээр зүйл

„(1) Австри улс тусгаар тогтнолоо тунхаглаж, өөрийн газар нутгийн халдашгүй дархан байдлыг хамгаалах зорилгоор, сайн дурын үндсэн дээр, байнга төвийг сахихаа зарлаж байна. Австри улс нь өөрт байгаа бүх бололцоогоор үүнийг сахин хамгаална.[8].

(2) Австри улс [төвийг сахих] зорилгоо сахихын тулд цаашид аливаа цэргийн эвсэлд нэгдэхгүй бөгөөд газар нутаг дээрээ бусад улсын цэргийн бааз байрлуулахгүй."

Төвийг сахих бодлогын хүрээнд хөрш зэргэлдээ оронд нь зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд *Австри улсын зэвсэгт хүчин* "төвийг сахих статусаа хуурай газар болон агаарын орон зайд хамгаалан бататгаж, гадны цэрэг Австрийн нутагт нэвтрэхээс сэргийлж, нэвтэрсэн

8 Австри улсын Байнга төвийг сахих бодлогоо Холбооны Үндсэн хуулийн 9-ийн А-д заасны дагуу сахин хамгаална.

тохиолдолд гадны цэргийн зэвсгийг хураах, тусгаарлах” үүрэгтэй (Fender 2013: 34). Австри улсын Төвийг сахих тухай хууль нь тус улс Дэлхийн 2 дугаар дайны дараа тусгаар тогтнолоо сэргээх, түүнчлэн, тухайн үеийн эзлэн захирагч орнууд болох Франц, Их Британ, ЗХУ болон АНУ-ын цэргийг бүрэн гаргах хүсэл зорилгоос эхтэй. 1955 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Төвийг сахих тухай хуулийг батлахаас нэг өдрийн өмнө эзлэн захирагч орнуудын хамгийн сүүлийн цэрэг Австри улсын нутгаас гарчээ (Hajnoczi 2005:7). Төвийг сахих бодлогыг дотоодын эрх зүйн баримт бичигтэй холбосноор “Төвийг сахихтай холбоотой үүрэг зөвхөн Австри улсын төрийн байгууллагууд, тодруулбал, *Европ, интеграцчилал, гадаад хэргийн яамны (BMEIA)* эрхлэх асуудал болжээ.” Тус улсын Тусгаар тогтнох гэрээг баталсан бусад улс Төвийг сахих тухай асуудалд оролцох эрхийг (эрх зүйн хувьд) хаажээ (Stolzlechner 2013: 78-аас хойш үзнэ үү).

Австри улсын тусгаар тогтнох гэрээг үзэглэсэн 4 орон 1955 оны 12 дугаар сарын 6-нд  ижилхэн нот бичиг гаргаж, тус улсын *байнга* төвийг сахих бодлогыг хүлээн зөвшөөрсөн юм. Найман өдрийн дараа буюу 1955 оны 12 дугаар сарын 14-нд НҮБ-ийн Аюулгүйн зөвлөлийн санаачилгаар Австри улс бусад 15 орны хамт[9] *Нэгдсэн Үндэстний Байгууллагын* гишүүн болжээ. Энэ үйл явдал НҮБ-ын ЕА-ийн 995 (X) тогтоолд үндэслэсэн юм. Австри улс НҮБ-д гишүүн болох хүсэлт гаргаад байхдаа буюу 1952 оны 8 дугаар сард “*НҮБ-ийн дүрмийн бүх заалтыг мөрдөж, сахин биелүүлэхээ мэдэгдсэн [...] бөгөөд эдгээр заалтад энх тайвны эсрэг этгээдэд албадан авах арга хэмжээний талаар ч заасан”* байжээ (Fender 2013: 2019). Дараах баримт бичгүүд Австри улсад Байнга төвийг сахих  хууль, эрх зүйн үндэс болдог.

- *Хуурай газрын дайны үед төвийг сахигч улс, этгээдийн эрх үүргийн талаарх Хаагийн* V *Конвенц* болон түүнийг хэрэгжүүлэх талаарх үндсэн хуулийн заалт, дотоодын эрх зүйн баримт бичиг  (RGBl. Nr 181/1913),
- Австри улс Төвийг сахих талаарх (BGBl. Nr. 211) 1955 оны 10 дугаар сарын 26-ны Холбооны Үндсэн хуультай адилтгах хууль (Fender 2013: 210).

*Австри улсын Төвийг сахих бодлого* нь үзэл суртал, эдийн засгийн хүрээнд бус *зөвхөн цэрэг дайны хүрээнд* хэрэгжих юм. Австри улс нь

9 Эдгээр орон нь Албани, Балба, Болгар, Финлянд, Ирланд, Итали, Иордан, Камбож, Лаос, Ливи, Португал, Румын, Испани, Шри Ланка, Унгар байв (Гадаад харилцаа, худалдааны яам 2013: 12-15)

*Байнга* төвийг сахигч хэдий ч *Нэгдсэн Үндэстний байгууллагын* гишүүн. Байнга төвийг сахигч Австри улс *Нэгдсэн Үндэстний байгууллагын* гишүүн болсноо ийнхүү тайлбарсан байна: НҮБ-ын дүрэмд шууд хэрэгжих хориг байхгүй. НҮБ-ын дүрэмд ямар нэг хориг арга хэмжээний талаар шууд тусгаагүй, харин Аюулгүйн зөвлөл тохиолдол тус бүрт хэлэлцэж, НҮБ-ын дүрмийн 39-ийн дагуу албадан хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрлэнэ. НҮБ-ын дүрмийн 25 дугаар зүйл болон 2-ын (5) дугаар зүйлийн дагуу тус байгууллагын гишүүн бүр Аюулгүйн зөвлөлийн гаргасан шийдвэр, ялангуяа, энх тайван болон олон улсын эрх зүйг зөрчсөн этгээдийн эсрэг хамтран зогсох шийдвэрийг даган, биелүүлэх ёстой. Гэвч, НҮБ-ын дүрмийн 48 дугаар зүйлийн дагуу зарим орон, түүний дотор төвийг сахигч орон үүнд хамрагдахгүй байх боломжтой (Neuhold/Hummer/Schreuer 1991: 488). Тухайлбал, НҮБ-ын албадан авах арга хэмжээ австрийн төвийг сахих бодлоготой зөрчилдөх тохиолдлыг үүнд нэрлэж байна (Hajnoczi 2005: 8). Гэвч, эрх зүйн энэ гаргалгаа 1990/91 онд Ирак улс Кувейтын эсрэг явуулсан дайны үед хэрэглэгдээгүй. Кувейт улсыг чөлөөлөхөөр 1991 онд АНУ-ын тэргүүлэн явуулсан олон улсын *Цөлийн шуурга* ажиллагааг НҮБ-ын дүрмийн 7 дугаар бүлгийн дагуу олон улсын эрх зүйд нийцэж байна гэж үзсэн. *Цөлийн шуурга* ажиллагаанаас үүдэн, Австри улсад НҮБ-ын дүрмийн дагуу хүлээсэн үүрэг Төвийг сахих тухай хуулиас давуу эрхтэй гэсэн эрх зүйн гаргалгаа хүлээн зөвшөөрөгджээ (Hajnoczi 2005: 8). Иймд, өнөөдрийн байдлаар НҮБ-ын дүрмээр хүлээсэн эрх, үүрэг нь төвийг сахих тухай хуулиас давуу байдаг жишиг улс орнуудад тогтсон (Stolzlechner 2013: 146). Австри улс нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолд үндэслэн 1960 оноос хойш энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцож байна. Ийнхүү энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцох эрх зүйн нөхцөл нь *Цэрэг, цэргийн анги нэгтгэлийг гадаад оронд илгээхэд хамтрах, эвлэлдэх тухай Үндсэн хуультай адилтгах хуулиар* бүрдэж байгаа юм (KSE-BVG BGBl I 1997/38 in der Fassung BGBl I 1998/35).

Австри улс 1995 онд төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч Финлянд, Шведийн хамтаар *Европын холбооны* гишүүн болжээ. Үүнд Европын орнуудын *Гадаад бодлого, аюулгүй байдлын нэгдсэн бодлого* харшилсангүй. Тухайн үеийн *Европын холбооны Маастрихтын гэрээний* J.4-1-ийн дагуу (урт хугацаанд) ЕХ-ны орнууд Нэгдсэн батлан хамгаалах бодлоготой байх зорилт тавьсан бөгөөд тэнд шаардлага гарвал хамтын батлан хамгаалах үйл ажиллагаа явуулахаар заасан (Hummer 2001:151). Австри улс Европын холбоонд нэгдсэнээр "Төвийг сахих тухай ойлголтод эрх зүйн болон улс төр, үзэл санааны өөрчлөлт орох шалтгаан бүрджээ" (Fender 2013: 217). Үүний улмаас Эв нэгдэл "төвийг сахихаас

илүү ач холбогдолтой болж, төвийг сахих үзэл санааны ач холбогдол үндсэн зарчим хүртлээ буурчээ (Fender 2013: 217).

2009 оны 12 дугаар сарын 1-нд *Европын холбооны тухай Лиссабоны гэрээ* хүчин төгөлдөр болсноор цэргийн талаас төвийг сахих бодлоготой харшилж болох гурван зүйл бий болжээ. Үүнд: бусад гишүүн орныг *Туслан дэмжих тухай* 42-7 дугаар заалт, ЕХ-ны гэрээний 222 дугаар зүйлд заасан *Эв нэгдлийн тухай заалт,* мөн гэрээний 43 дугаар зүйлд заасан холбооны газар нутгаас гадна цэргийн үйл ажиллагаа явуулах тухай заалтууд багтана. Австри улс Европын холбооны гишүүн болсноор төвийг сахих бодлого нь *Төвийг сахих сонгодог хэлбэр талаасаа тайлбарлагдах болов.* Өөрөөр хэлбэл Австри улс аливаа цэргийн эвсэлд нэгдэхгүй, бусад улсын цэргийн баазыг өөрийн газар нутагт байрлуулахгүй гэдэг зарчимд суурилав (Fender 2013: 217). Гэвч, Австри улс *Европын холбооны Аюулгүй байдал, батлан хамгаалах нэгдсэн бодлого* боловсруулахад идэвхтэй оролцож байна: 2012 оны 4 дүгээр сарын 24-нд Австрийн хошууч-генерал Волфганг Восолсобег *(Wolfgang Wosolsobe)* ЕХ-ны гишүүн орнууд ЕХ-ны Жанжин штабын даргад нэр дэвшүүлсэн бөгөөд тэрээр 2013 оны 5 сард энэ ажлыг хүлээн авчээ. ЕХ-ны Жанжин штаб нь Европын холбооны цэргийн стратеги боловсруулах төв бүтэц юм. Энэхүү газрын дарга нь дэслэгч-генерал буюу гурван одтой генерал байх бөгөөд түүний үүрэгт хугацаа 3 жил байна (Батлан хамгаалах, спортын яам 2016: 26).

2013 оны 7 дугаар сард баталсан *Австри улсын аюулгүй байдлын стратегийн (ÖSS)* дагуу Европын холбоо нь тус улсын "аюулгүй байдлын стратегийн хэрэгжилт, үйл ажиллагааны гол хүрээ байх юм. Үүний тулд Гадаад харилцаа, аюулгүй байдлын нэгдсэн бодлогыг урагшлуулахад оролцохоос гадна Аюулгүй байдал, батлан хамгаалах нэгдсэн бодлогод идэвхтэй, эв нэгдэлтэйгээр хувь нэмрээ оруулах шаардлагатай" хэмээн Австрийн Батлан хамгаалахын сайд Геральд Клуг *(Gerald Klug)* тэмдэглэжээ (Klug 2013: 7).

„Европын холбоо бие даасан гадаад бодлого явуулах боломж нэмэгдэж, олон улсын аюулгүй байдлын асуудлаар НҮБ тэргүүлэх байр суурьтайг хүлээн зөвшөөрч, мөн ЕХ-ны Аюулгүй байдал, батлан хамгаалах нэгдсэн бодлого дахь иргэний болон цэргийн хамтарсан арга барилыг илүү тодотгож, хэрэгжүүлэх нь ЕХ-ны гишүүн, төвийг сахидаг манай улсын хувьд чухал асуудал юм" (Klug 2013: 7). Европын холбооны цогц хандлагыг „тус холбооны гадаад руу чиглэсэн үйл ажиллагааны зарчим, эсвэл цэргийн томъёоллоор, үүрэг даалгаврын тодорхойлолт гэж харж болно" (Lattacher 2014: 4).

Энэхүү хандлагын дагуу, аюулгүй байдал, батлан хамгаалах (хямралыг

зохицуулах үеийн иргэний болон цэргийн байгууллагын уялдаа), хөгжил (хүмүүнлэгийн тусламж, хөгжлийн хамтын ажиллагаа г.м.) болон улс төр, дипломат ажиллагаа (энх цагийн дипломат ажиллагаагаас хориг хүртэл) зэрэг салбарын арга хэмжээ, хэрэгсэл нь хямралтай тэмцэх үед нэгдэж болж байна (Lattacher 2014: 4).

Австри улс 1995 онд *НАТО-гийн Энхийн төлөө түншлэлийн (Partnership for Peace - PfP)* гишүүн болсон. Гэвч энэ гэрээ нь "олон улсын эрх зүйн бичиг баримт гэхээс илүүтэй НАТО-Австрийн харилцааны төрхийг харуулсан улс төрийн зорилготой баримт бичиг" болжээ (Fender 2013: 220). Энхийн төлөө түншлэлийн хүрээнд олон улсын цэргийн хамтын ажиллагаа, цэргийн бэлтгэл, сургуулилт болон НАТО-гийн тэргүүлсэн олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулагддаг. Түүнчлэн, Энхийн төлөө түншлэлийн хүрээнд Австри улс "аливаа үүрэг хүлээхгүйгээр, хоёр талт харилцаанд тулгуурлан" НАТО-той харилцаагаа бэхжүүлж "Атлантын далай дамнасан яриа хэлэлцээ"-нд оролцох боломжтой болсон (Батлан хамгаалах, спортын яам 2013: 27). Австри улс Энхийн төлөө түншлэлийг зэвсэгт хүчнийхээ шинэчлэл, түүнчлэн, бусад зэвсэгт хүчинтэй хамтран ажиллахад шаардлагатай уялдаа холбоог бэхжүүлэх дасгал, сургалт явуулах, нэгдмэл стандарт бий болгоход ашиглаж байна (Батлан хамгаалах, спортын яам 2013: 27).

НАТО үйл ажиллагаанд нь оролцох сонирхолтой Финлянд, Ирланд, Австри, Швед зэрэг түнш орнууддаа зориулсан *Operational Capabilities Concept (OCC)* буюу Зэвсэгт хүчний хамтран ажиллах чадвар, стандартчиллын хөтөлбөр боловсруулжээ. *Австрийн зэвсэгт хүчин OCC*-ийг мэргэжлийн цэргийн бэлтгэлд ашиглаж байна. 2010 онд Австри улс хуурай газрын цэргийнхээ бэлэн байдал болон гүйцэтгэлийн чадварыг шалгуулсан анхны НАТО-гийн энхийн төлөө түншлэлийн орон болсон (Батлан хамгаалах, спортын яам 2013:27). Шалгалтыг ихэнх тохиолдолд өөр олон улсын багуудтай хамт хийдэг. *Нэгдүгээр* шатанд бусад орны багтай хамтран ажиллах чадварыг шалгадаг бол *хоёрдугаар* шатанд өгөгдсөн даалгаврыг хэр биелүүлснийг шалгадаг юм (Naderer 2014: 5). Шатлал бүрийн төгсгөлд *Final Feedback Report* буюу Үнэлгээний тайлан гардаг. Тайлан нь давуу болон сул талыг гаргахаас гадна, сул талуудаа яаж багасгах талаар зөвлөмж өгдөг.

„Энэхүү үнэлгээ нь тус орны зэвсэгт хүчин төдийгүй олон улсын цэргийн ажиллагаа төлөвлөж буй мэргэжилтнүүдэд хэрэгтэй юм. Учир нь тэд түнш орнуудын зэвсэгт хүчний чадвар, дутагдалтай талыг харж төлөвлөгөөнд тусгах боломжтой (Naderer 2014: 5).

Дээрх арга барилын амжилтыг харуулсан зарим жишээ болгон Косовод

*(Kosovo Force - KFOR)* оролцсон Австрийн анги нэгтгэл болон Герман-Австрийн нөөцийн холимог батальоныг дурдаж болно (Naderer 2014: 5). Энхийн төлөө түншлэлд оролцсоноор Австри улс НАТО-гийн өмнө үүрэг хүлээхгүй тул Австрийн “төвийг сахих бодлогод харшлахгүй” (Fender 2013: 220).

*Петерсбергийн үүргээс* улбаалж 1997 онд анх удаа Европын холбооны гэрээнд байлдааны үйл ажиллагааны талаар тусгасан. *Петерсбергийн үүргийг* Австри улс Холбооны үндсэн хуультай адилтгах хуулиндаа 23f нэмэлт заалт болгон (2010 онд 23j заалтаар өргөжсөн) оржээ. Ингэснээр “Австри улсын төвийг сахих бодлоготой холбоотой эрх зүйн өөрчлөлт гарсан юм” (Hummer 2001:162). 1995 онд Австри улс Европын холбооны гишүүн болсноор 90-ээд оны дунд үед анх Холбооны Үндсэн хуультай адилтгах хуулийн 23f заалтын дагуу зөвхөн *улс төрийн сэдэлтэй* аливаа эдийн засгийн хоригт оролцох боломжтой болжээ. Өөрөөр хэлбэл НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хориг давхар байх албагүй болж. Гагцхүү энэ алхмаар Австри улсын *Байнга төвийг сахих бодлого харьцангуй төвийг сахих болон өөрчлөгджээ.* Иннсбрукийн их сургуулийн олон улсын эрх зүйч Валдемар Хуммер *(Waldemar Hummer*)-ийн үзэж буйгаар Австри улс *Петерсбергийн үүргийг* хүлээн зөвшөөрснөөр төвийг сахих бодлого нь ердийн “эвсэлд үл нэгдэх” чиглэлд хувирчээ (Hummer 2001: 162). Австри улс Европын холбооны гишүүн болсон явдал, ЕХ-ны эрх зүйн хөгжил зэрэг нь “төвийг сахих бодлогын эрх зүйн агуулгыг өөрчилсөн” хэмээн Зальцбургийн их сургуулийн эрдэмтэн, Үндсэн хуулийн эрх зүйч Харалд Штолцлехнер *(Harald Stolzlechner)* дүгнэжээ (Stolzlechner 2013: 79).

Австри улс дотоод, гадаад улс төрийн нөхцөл байдалд тааруулж төвийг сахих бодлогоо уян хатан тайлбарлаж ирсэн. Ийнхүү төвийг сахих бодлого нь “олон арван жилийн явцад Австри улсын онцлог шинж чанарын нэг хэсэг болсон юм” (Fender 2013:10). Үндсэн хуулийн хэмжээнд дархлагдсан  төвийг сахих бодлогыг өөрчлөх, эсвэл бүрэн халах болбол *Үндэсний зөвлөлийн* гишүүдийн 2/3-аас багагүй санал хэрэгтэй. *Үндэсний зөвлөлийн* гишүүдийн 1/3 шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Холбооны үндсэн хуультай адилтгах хуулийн 44 дүгээр зүйлийн гуравдугаарт заасны дагуу нийт ард түмний дунд сайн дурын санал асуулга явуулж Үндсэн хуулийг өөрчилж болно. Иймд, байнга төвийг сахих нь “үндсэн хуулийн түвшинд зохицуулагдсан гадаад бодлогын үйл ажиллагааны зарчим болохоос үндсэн хуулийн хэм хэмжээг тогтоох зарчим биш юм (Stolzlechner 2013: 82).

2011 оны 3 дугаар сарын 1-нд Австри улсын засгийн газар *“Ойрын аравны аюулгүй байдал-аюулгүй байдлыг цогцлоох нь*” гэсэн

гарчигтайгаар аюулгүй байдлын шинэ стратегиа боловсруулж Үндэсний зөвлөлд хэлэлцүүлжээ (Braumandl-Dujardin 2013: 5). Үндэсний зөвлөлийн XXIV чуулган дуусахаас хэдхэн өдрийн өмнө буюу 2013 оны 7 дугаар сарын 3-нд Австри улсын аюулгүй байдлын шинэ стратегийг *(ÖSS)* баталжээ. Австрийн Социал Демократ нам *(SPÖ),* Австрийн Ардын нам (*ÖVP),* Австрийн Эрх чөлөө нам *(FPÖ)* болон *Team Stronach* намууд аюулгүй байдлын шинэ стратегийг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэж 2013 оны 7 дугаар сарын 3-нд "хүлээн авав" (БНАУ/Парламент 2013). Эдгээр нам Батлан хамгаалах байнгын хорооны баталсан шийдвэртэй санал нийлж, аюулгүй байдлын шинэ стратегийн гол зарчмыг баталгаажуулав. Үүгээр Аюулгүй байдлын шинэ стратеги нь тус улсын улс төр-стратегийн чиг шугам, ирэх 10 жилд аюулгүй байдлын бодлогоо хэрхэн явуулах талаар хууль тогтоогчдоос Засгийн газарт өгсөн зөвлөмж болов" (Frank 2013: 191). Австрийн Ирээдүй эвсэл *(BZÖ)* болон Ногоон нам аюулгүй байдлын шинэ стратегийн эсрэг санал өгчээ.

Австрийн засгийн газар Аюулгүй байдлын шинэ стратеги батлуулснаараа хувьсан буй орчинд аюулгүй байдлын сорилтуудыг шийдвэрлэхийг зорьжээ. Ингэхдээ Холбооны зэвсэгт хүчний үүрэг хариуцлагыг онцгойлон авч үзсэн юм (БНАУ/Парламент 2013). Австрийн Ирээдүйн эвсэл нам (BZÖ) Аюулгүй байдлын шинэ стратегиас татгалзсан шалтгааныг Батлан хамгаалах сайд асан Херберт Шрайбер (*Herbert Schreiber, FPÖ* намын гишүүн асан, 2005 оноос хойш *BZÖ*) тайлбарлахдаа "энэ баримт бичигт цэргийн үүргийг тодорхой гаргаагүй бөгөөд Европын аюулгүй байдлын бүтцийн хүрээнд хэрэгжих ажиллагаа нь байнга төвийг сахих зарчмыг тууштай баримтлахад харшилж байна" гэжээ. Харин үүнд Батлан хамгаалахын сайд Гералд Клуг *(SPÖ)* дараах хариултыг өгсөн байна:

„Төвийг сахих нь манай улсын аюулгүй байдлын бодлогын хувиршгүй зарчим. Энэхүү стратегид аливаа цэргийн эвсэлд нэгдэхгүй гэдгийг тодорхой заасан тул НАТО-д элсэхгүй нь илэрхий байна" (БНАУ/Парламент 2013).

Байнга төвийг сахина гэдэг нь "идэвхтэй, энх тайванч гадаад бодлогын хүрээнд" ойлгогдох ёстой:

„Иймд, энэхүү аюулгүй байдлын стратеги төвийг сахих болон Европын холбооны эв нэгдлийн хоорондох тэнцвэр, мөн үндэсний аюулгүй байдал болон олон улсын тогтвортой, нэгдмэл байдалд тэнцвэртэй хандах боломжийг эрэлхийлж байна" (Frank 2013: 191).

Австрийн аюулгүй байдлын стратегийн дагуу Европын холбоо нь "Австри улсын аюулгүй байдлын бодлогын чухал талбар" хэвээр үлдсэн

бол төвийг сахих бодлого дахин “Австрийн гадаад болон аюулгүй байдлын бодлогын үндсэн зарчим” болсноороо 2001 онд батлагдаж байсан Аюулгүй байдал, батлан хамгаалах номлолоос ялгарч байна (Frank 2013:195). Түүнчлэн, Австрийн аюулгүй байдлын стратегийн дагуу төвийг сахисан Австри улсын аюулгүй байдал Европын холбооны аюулгүй байдалтай нягт холбоотой юм (БНАУ 2013:1). Ийм учраас тус улс нь „Европын холбооны Аюулгүй байдал, батлан хамгаалах нэгдсэн бодлогын тууштай дэмжигч бөгөөд Европын аюулгүй байдлын нийтлэг соёл (зарчим, үзэл баримтлал)-ыг дэмжиж түгээх онцгой сонирхолтой юм.” (Klug 2014:7). НҮБ, Европын холбоо, *Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)*, НАТО-гийн түншлэл, *Европын зөвлөл* дэх хамтын ажиллагаа Австри улсын хувьд тэргүүлэх байр суурьтай бөгөөд бүс нутгийн орнууд, бусад түнштэй ч хамтран ажиллаж байна (БНАУ 2013:5). Австри улс тогтвортой, ардчилсан улсуудтай хиллэдэг хэдий ч хямрал гарах өндөр магадлалтай Европын захын бүс нутагт ойрхон тул тогтворгүй байдалтай тулгарах нь түгээмэл (БНАУ 2013:5).

“Австри улсын газар зүйн байрлал, аюулгүй байдлын бодлогын нөхцөл байдал, хуримтлуулсан туршлагаас хамааран *Зүүн өмнөд болон Зүүн Европ, түүнчлэн Ойрх Дорнод дахь ажиллагаа* тэргүүлэх байр суурь эзэлнэ хэмээн тус улсын аюулгүй байдлын стратегид заажээ:

> “Олон улсын харилцааны хувьсал, тухайн бүс нутаг дахь нөхцөл байдлаас хамааран Австри улс өөрийн оролцоог тааруулж, шаардлагатай тохиолдолд Балкан, Дунай мөрний орчин, Хар тэнгис, Голаны өндөрлөг, Ойрх болон Дундад дорнод хийгээд Африкийн хойд хэсэг хүртэл үйл ажиллагаагаа өргөжүүлж болно (БНАУ 2013:13f).

Австри улсын Гадаад хэргийн сайд Себастиан Курц *(Sebastian Kurz)* 2013 оны 12 дугаар сард хэлсэн үгэндээ:
“Австри бол төвийг сахигч улс. Төвийг сахих нь манай улсыг тодорхойлдог зүйлийн нэг. Европт гадаад бодлого, аюулгүй байдлын нэгдсэн бодлого хэрэгтэй гэдэг нь тодорхой. Гэхдээ энэ нь газар нутгаа цэргийн хүчээр хамгаалахаас илүү өргөн агуулгатай юм” гэжээ (Koller/Smetana 2013: 2).
Тэрээр “би төвийг сахих бодлогыг тууштай дэмжигч. Гэхдээ нэгдмэл Европт төвийг сахих үзэл баримтлал үгүй болж байна” гэдгийг тэмдэглэв. “Харин манайх шиг жижиг, онцлог оронд төвийг сахих нь тодорхой тохиолдолд “гүүр”-ийн үүрэг гүйцэтгэх боломж бүрдүүлж байна. Ийм учраас төвийг сахих нь бидний хувьд ямар ч тохиолдолд давуу тал юм” (Koller/Smetana 2013: 2).

# 7. Эвсэлд үл нэгдэх ба Төвийг сахих бодлого - Швед, Финлянд, Ирланд, Мальта

## 7.1 Швед улс

Швед хэлбэрийн төвийг сахих байр суурь нь *эвсэлд үл нэгдэхээс* илүү гүн агуулгатай юм: энхийн цагт *эвсэлд нэгдэхгүй*, дайны цагт *төвийг сахина.* Швед улс яг хэзээ төвийг сахих шийдвэрт хүрсэн нь тодорхойгүй. Дэлхийн II дайны үеэр германы цэрэг Норвеги, Финлянд руу явах замдаа ихэвчлэн Шведээр дайрч өнгөрдөг байжээ. Шведүүд бүр 1939 оны Финлянд-Оросын дайны үед зүүн хөршөө дэмжиж зэвсэг, 5 бөмбөгдөгч, 12 байлдааны онгоц, 8 тагнуулын онгоц, 8000 хүнтэй сайн дурынхнаас бүрдсэн корпус нийлүүлж байсан (Hauser 2002:50-ийг үзнэ үү). 1946 онд Швед *НҮБ-д* элсэхдээ тус байгууллага үйл ажиллагаагаа явуулах чадваргүй болсон тохиолдолд хатуу төвийг сахих эрхээ эргэн сэргээх нөхцөлтэйгөөр гишүүн болсон байдаг. Шведийн төвийг сахих байр суурь нь олон улсын эрх зүй болон дотоодын хууль тогтоомжоор баталгаажаагүй, зөвхөн Парламентаас гаргасан тунхаглалтай, уян хатан тайлбарлах боломжтой байжээ. Швед улс ЗХУ-д итгэл үнэмшил төрүүлэхүйц гадаад бодлого явуулах шаардлагатай байсан ч Австри, Швейцарийг бодвол энхийн цагт эрх зүйн аливаа үүрэг хүлээхээргүй ажээ (Hauser 2002:50-тай харьцуулна уу).

Шведийн цэрэг 1960 онд Конгод явуулсан ажиллагаанаас эхлэн НҮБ-ын ажиллагаанд Австрийн нэгэн адил оролцож байна. 1968 онд Дани, Финлянд, Норвеги улс хамтран *Nordic-Stand-by-Force* үүсгэн байгуулсан: 4000 хүний бүрэлдэхүүнтэй, голчлон цэргийн ажиллагаа явуулах зорилготой ч энхийг сахиулахад бас хамтардаг. НҮБ-ын дүрмийн VII бүлгийн заалтын дагуу эдгээр ажиллагаанд оролцдог (Hauser 2002:52-ыг үзнэ үү). *Скандинавынхны аюулгүй байдал, батлан хамгаалах хамтын ажиллагаа* улам өргөжин тэлж, зэр зэвсгийн салбарт хамтрахын зэрэгцээ, үйл ажиллагаа явуулах хамтарсан нэгж байгуулав. „Бид зардлын үр ашгийг дээшлүүлэхийг зорихын зэрэгцээ үйл ажиллагаа, санхүү, техник, аж үйлдвэрлэлийн давуу талыг бий болгохыг эрмэлзэнэ.“ (Partanen 2013: 116-г үзнэ үү). Норвеги, Шведийн жанжин штабын дарга нар илүү гүнзгий, сайн зохион байгуулалттай хамтын ажиллагааг санаачилж, Финляндын штабын даргыг зөвлөлдөөндөө урьсан байна. Ингээд 2006 оны 7 дугаар сард 3 орны штабын дарга нарын гаргасан тайланд 140 чиглэлээр хамтран ажиллах боломж

буй бөгөөд тэдгээрээс 40 чиглэлд даруй хамтын ажиллагаа эхлүүлж болохыг тодорхойлжээ (40-ийн жагсаалт). Тухайн үед Скандинавын Батлан хамгаалах хамтын ажиллагааг *(Nordic Defence Cooperation, NORDEFCO)* шинээр эхлүүлснийг дараах байдлаар тодорхойлов: „Энэ нь дуусаагүй гүйцэтгэж буй ажил хэдий ч бидний хэдэн арван жилийн турш үргэлжилсэн хамтын ажиллагаатай харьцуулахад хэзээ нэмэлт үр өгөөж авчрахыг хэлэхэд арай эрт байна“ (Partanen 2013: 116).

Швед улс Финляндын нэгэн адил НАТО-гийн хамтран ажиллах стандарт, цэргийн худалдан авах ажиллагааны шаардлагыг мөрдлөг болгодог: “түүнчэн, ЕХ болон Скандинавын орнуудын батлан хамгаалах хамтын ажиллагаанд адил стандарт хэрэглэдэг” (Partanen 2013: 113). Умард Европын 5 орны аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого нь өөр өөр байдаг: Финлянд, Швед гэхэд ЕХ-ны гишүүн бөгөөд НАТО-гийн түншлэгч орон бол Норвеги, Исланд зөвхөн НАТО-гийн гишүүн орнууд юм. Дани хэдийгээр НАТО, ЕХ-ны аль алины гишүүн боловч ЕХ-ны Аюулгүй байдал, батлан хамгаалах нэгдсэн бодлого (*GSVP*)-д оролцдоггүй. Ийм учраас *NORDEFCO* уян хатан гэдгээ батлан харуулдаг. Оролцох төсөл, ажиллагаагаа улс болгон өөрөө сонгож, хоёр болон гурван талт хамтарсан төсөл, үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжтой байдаг. *NORDEFCO* улс төр, цэргийн зохицуулалтын механизм дээр тулгуурладаг агаад байнгын бүтэц, байнгын ажилтан гэж байдаггүй (Partanen 2013: 117-г үзнэ үү).

Швед 1991 оны 7 дугаар сарын 1-нд ЕХ-нд элсэхээр өргөдөл өгөхдөө төвийг сахих тухай заалт оруулаагүй юм. 1994 оны 11 дүгээр сарын 13-ны санал асуулгаар ард иргэдийн 52,3 хувь нь ЕХ-нд элсэхийг дэмжсэн аж (Hauser 2002:52 –ыг үзнэ үү). 2000 оны 10 дугаар сард тухайн үеийн Ерөнхий сайд Гёран Перссон (*Göran Persson*) хүйтэн дайн дуусч, их гүрнүүдийн хооронд сөргөлдөөн үгүй болсон тул төвийг сахих нь ач холбогдолгүй болсон гэж үзжээ. Мөн түүнчлэн Батлан хамгаалахын сайд Бёорн фон Сюдов *(Björn von Sydow*) 2000 оны 11 дүгээр сард “Швед эвсэлд үл нэгдэх орон, цаашид ч ийм байх болно (Hauser 2002:52-ыг үзнэ үү). Төвийг сахих нь хүйтэн дайнтай холбоотой тул одоо ач холбогдолгүй болсон” хэмээн мэдэгджээ. 2002 оны 2 дугаар сарын 11-нд Засгийн газар (Социал-демократ нам) сөрөг хүчний гурван намтай (Консерватив, Төв, Христэд итгэгчдийн нам) зөвшилцсөний эцэст төвийг сахих үзэл баримтлалаасаа албан ёсоор татгалзсан юм (Hauser 2002: 53-ыг үзнэ үү). Цаашид аюулгүй байдал, энх тайванд учрах сорилтоос ”хамтын хүчээр болон бусад улс орнуудтай хамтран” хамгаалах нь илүү чухал. Хэрвээ ЕХ-ны аль нэг орон дайралтад өртвөл төвийг сахиад байх боломжгүй болно (Hauser 2002:53-ыг үзнэ үү). Шведийн Засгийн газраас:

„Европын Холбооны аль нэг гишүүн, түнш улсын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдсэн тохиолдолд (магадлал маш багатай) Швед төвийг сахисаар байна гэж төсөөлөхөд ч хэцүү“ (Bjurner 2005: 36) хэмээн шийдвэртэй илэрхийлжээ.

Гэхдээ Шведийн Засгийн газар НАТО-д дэмжлэг үзүүлэх баталгаа өгөх үндэслэл байхгүй гэж үздэг. Учир нь „Швед улс цэргийн эвсэл холбооны гишүүн биш бөгөөд батлан хамгаалах баталгаа олгосон аливаа гэрээ хэлэлцээрт нэгдээгүй“. [10] Энэ бодлогыг Парламент дахь улс төрийн намуудын дийлэнх, иргэдийн ихэнх нь дэмждэг (Bjurner 2005: 36-г үзнэ үү).

Хамтын ажиллагаа, эв санааны нэгдэл Шведийн аюулгүй байдлын бодлогын тулгын чулуу хэвээр байна: „Швед цэргийн эвсэлд үл нэгдэх бодлогыг олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хамгаалахад тууштай, идэвхтэй оролцох оролцоотойгоо хослуулдаг“ (Bjurner 2005: 35-ыг үзнэ үү). Шведийн аюулгүй байдал, гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь *хүний эрхийг хамгаалах*, *олон улсын эрх зүйг хүндэтгэх* явдал тул олон улсын цэргийн ажиллагаанд, ялангуяа НҮБ-ын мандаттай цэргийн шилдэг хүрээний ажиллагаанд оролцдог” (Bjurner 2005: 37-г үзнэ үү). Хүмүүнлэгийн онцгой байдал тулгарсан ч цэргийн ажиллагаа явуулахад НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс хориг тавих тохиолдол гарч болно. Энэ нөхцөлд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн олгосон мандат, ЕАБХАБ-ы урилга, эсвэл сөргөлдөгч талуудтай хийсэн тохиролцоо зэрэг нь цэргийн ажиллагаа явуулах эрх зүйн үндэс болж болно (Bjurner 2005: 37-г үзнэ үү).

Швед НАТО-гийн гишүүн бус Финляндын нэгэн адил *НАТО-гийн шуурхай ажиллагааны хүчний өндөржүүлсэн бэлэн байдлын нэгжид (NRF)* оролцдог бөгөөд 2014 онд *Saab JAS 39 Gripen* байлдагч онгоцны салаа, мина устгагч хөлөг онгоцоо нийт 120 цэргийн хамтаар хамруулсан (Atlantic Council 2014-ийг үзнэ үү). 2015 онд нэмэлт 8 групп *Gripen* болон газар уснаа явагчийн нэгж *NRF*-д нийлүүлэхээр төлөвлөсөн. Үүнтэй уялдан Шведийн Батлан хамгаалахын сайд Карин Энстроем *(Karin Enström)*:

„Тэд Шведэд байрлах боловч хэзээд үүргээ биелүүлэхэд бэлэн байх болно […] Эдгээр нэгж нь ажиллагаанд оролцоход хангалттай сайн бэлтгэгдсэн гэсэн НАТО-гоос олгосон сертификаттай юм“ (Atlantic Council 2014) гэв.

Энстроем хэлэхдээ Швед НАТО-той түншлэлийн бат харилцаатай гээд „НАТО-гийн Хариу үйлдэл үзүүлэх хүч болон Шуурхай ажиллагааны

10 Шведийн засгийн газрын хуулийн төслөөс эшлэв. 2004/05: 4 (vgl. Huldt 2005: 43).

хүчний нэгдэлд оролцож, хувь нэмэр оруулснаар түншлэлийн харилцаа маань улам хөгжинө. Харин НАТО-гийн гишүүнчлэлийн асуудал маш чухал шийдвэр байх болно.“ (O´Dwyer 2014a: 22) хэмээн тэмдэглэжээ.

Одоогийн байдлаар Парламентад суудалтай 8 намын хоёрхон нь л НАТО-д элсэхийг дэмжээд байна (O´Dwyer 2014a: 22).

## 7.2 Финлянд

Финлянд төвийг сахих болсон нь дэлхийн II дайны дараа ЗХУ-аас улс төрийн хамааралтай байсны үр дагавар юм. Финлянд улс төрийн системийн хувьд Өрнөдийг баримжаалдаг байсан хэдий ч дорнод хөрштэйгөө *итгэлцэл бий болгох* шаардлагатай байжээ. 1947 онд ЗХУ-ын шахалтаар Финляндын Засгийн газар Маршаллын төлөвлөгөөнд оролцохоос татгалзсан ч АНУ-аас 120 сая ам.долларын зээл авсан байна (Hauser 2002: 58-ыг үзнэ үү).

1948 оны 4 дүгээр сарын 6-нд ЗХУ-тай *Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах тухай гэрээнд* Финлянд гарын үсэг зурсан байдаг. Ингэснээрээ Финлянд улс нь төвийг сахисан биш боловч бодлого нь төвийг сахихад чиглэсэн байсан гэхэд болно (Hauser 2002: 58-ыг үзнэ үү). Гэрээний 4 дүгээр зүйлд Финлянд ЗХУ-ын өмнө түүний эсрэг чиглэсэн холбоонд оролцох [гүй байх] үүрэг хүлээжээ. 1952 онд тухайн үеийн Ерөнхий сайд Урхо Кекконэн (*Urho Kekkonen*) домог болсон “унтлагын хувцасны халаасны” *(pyjama pocket speech)* яриандаа Финляндын төвийг сахих байр суурийг аюулгүй байдлын бодлогын зорилт гэдгийг анх удаа албан ёсоор тодорхойлсон.[11]

Хельсинкээс баруун зүгт 30 км зайд оршдог Порккала цэргийн баазад байсан ЗХУ-ын 40.000 цэрэг гарсны дараа (Häikiö 2000: 205) 1956 онд ЗХУ-ын нам, төрийн удирдагч Никита Хрушов ЗХУКН-ын XX их хурал дээр “энх тайвнаар зэрэгцэн орших” номлолын дагуу, “энх тайванч санаачилгаа” харуулж, ЗХУ болон түүний дагуул улсуудад заналхийлээгүй тул тус улсыг “сайн” гэж үзэн төвийг сахисан байр суурийг нь анх удаа хүлээн зөвшөөрсөн (Hauser 2002: 58):

„Дайны дараа төвийг сахих нь ЗХУ-аас зай барих арга хэрэгсэл болж байжээ. Ийм учраас Шведийг бодвол Финляндын хувьд төвийг сахих нь тийм ч чухал асуудал биш байж магадгүй юм.“ (Häikiö 2000: 199).

11 Энэ үедээ Kekkonen эмнэлэгт хэвтэж байсан (Häikiö 2000: 205-ыг үзнэ үү).

Түүнчлэн Финляндын төвийг сахих байр суурийг Франц, АНУ, Их Британи улс хүлээн зөвшөөрсөн. Тэр ч байтугай Дани, Норвеги улсыг хэрхэн НАТО-гоос гаргах талаарх шинэ санаачилгаа Кекконэн бүр 1957 оны нэгдүгээр сард танилцуулж байсан аж (Häikiö 2000: 207). Бас 1989 онд ЗХУ-ын нам, төрийн удирдагч Михаил Горбачев Хельсинкэд айлчлах үеэрээ Финляндыг төвийг сахигч гэж цохон тэмдэглэсэн. ЗХУ задран унасны дараа 1992 оны нэгдүгээр сард Финлянд улс хоёр талын харилцааны үндсэн зарчмын тухай гэрээг Оростой байгуулсан байдаг. Энэхүү гэрээнд 1948 оны гэрээний ямар ч заалт ороогүй (Hauser 2002: 59). Хэдийгээр Финлянд төвийг сахих бодлоготой ч АНУ "Финлянд барууныг баримталсан бодлого явуулна гэдэгт итгэлтэй" байлаа (*Ruddy 2000: 20)*.

1955 онд Финлянд НҮБ-ын гишүүн болсон бөгөөд үүнээс 3 жилийн өмнө Скандинавын Парламент болон гишүүн орнуудыг зохицуулах хорооны зөвлөлд орсон. 1956 оноос эхлэн Финлянд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож ирэв. 1969 онд *Эдийн Засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-д* элсжээ. 1994 онд Швед, Финлянд хоёрыг НАТО-гийн Энхийн төлөө түншлэлд хамруулсан (Hauser 2002: 58-аас хойш үзнэ үү). "Оросууд Чечений Грозный хотыг бөмбөгдсөн тэр өдөр" буюу 1995 оны 1 дүгээр сарын 1-нд Финлянд Европын холбоонд нэгдсэн байдаг (Visuri/Paavonen 2000: 251). Үүний дараа ЕХ-ны Гадаад бодлого, аюулгүй байдлын нэгдсэн бодлогын хүрээнд хүлээсэн үүргийнхээ дагуу "Чечений дайны талаарх саналаа" ЕХ-той уялдуулах шаардлагатай болсон (Visuri/Paavonen 2000: 251).

1995 оны 2 дугаар сарын 14-д Финляндын Засгийн газар ЕХ-ны бодлогын талаар мэдэгдэл хийсэн бөгөөд Ерөнхий сайд Еско Ахо *(Esko Aho)* гадаад бодлогын чиг шугамаа танилцуулж, "Финлянд бие даасан, найдвартай батлан хамгаалахтай, эвсэлд үл нэгдэх орны хувьд ЕХ-нд элслээ. Төвийг сахих язгуур шугамаа цаашид үргэлжлүүлэх болно [...]" гэж онцлон тэмдэглэжээ (Visuri/Paavonen 2000: 252). Тэгэхээр Финляндын үзэж байгаагаар 1995 оноос эхлэн гадаад бодлого, аюулгүй байдлын бодлого нь эвсэлд үл нэгдэх агаад аюулгүй байдлын бодлогын статусын хувьд *төвийг сахисан* гэдэг нэр томъёо дахин хэрэглэгдэхгүй болсон.

„Найдвартай батлан хамгаалах чадвартай байж, олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд оролцохын хамт төвийг сахих байр суурийн үндэс болох цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байх нь Финляндын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын гол тулгуур мөн" (Möttölä 2005: 17f.).

1994 оны 10 дугаар сарын 16-нд явуулсан бүх нийтийн санал

асуулгаар[12] дийлэнх финчүүд “Баруунд лавтай хамаарагдах цорын ганц боломж бол өөрсдийгөө “эрх чөлөөтэй” Баруун хэмээн хүлээн зөвшөөрөх явдал гэж үзсэн” (Visuri/Paavonen 2000: 250). Тэр бүү хэл 1997 онд төвийг сахих нь ЕХ-ны гишүүнчлэлтэй үл нийцнэ, өөрөөр хэлбэл, Финлянд элсэн орвол ЕХ-ны эв санааны нэгдлийн зарчимтай нийцэхгүй гэсэн байдаг: „[Европын] Холбоо болон гуравдагч этгээдийн хооронд мөргөлдөөн үүсвэл Финлянд оролцохгүй байж болохгүй“[13] Ингэснээр Финлянд ЕХ-ны батлан хамгаалах үйл хэрэгт оролцохоо үгүйсгээгүй гэсэн үг юм (Möttölä 2005: 19-ийг үзнэ үү).

2003 оны хоёрдугаар хагаст Финляндад НАТО-д элсэх талаар яригдаж эхлэв. Анх Засгийн газрын тэргүүлэх улс төрч, Рейхстаг дахь гадаад бодлогын хорооны дарга, Социал демократ намын Лиза Яаконсаари *(Liisa Jaakonsaari)* НАТО-д элсэх талаар хэлэхдээ “урт удаан хугацаанд гэр бүл шиг байсан хамтын амьдралыг бүртгүүлэх цаг нь одоо болсон” гэжээ (Lucius 2003: 7). Тэрээр Финляндын арми аль хэзээнээс зэвсэглэл, сургалт болон стратегийн асуудлаар НАТО-той холбоотой байж ирсэн хэмээн цохон тэмдэглэсэн (von Lucius 2003: 7-г үзнэ үү).

2010 онд тухайн үеийн Гадаад хэргийн сайд Александр Стубб *(Alexander Stubb)* нэгэн ярилцлагадаа Финлянд НАТО-гийн талаар *Нээлттэй хаалганы бодлого* барьдгийг онцлоод, Финляндад дараах гурван сонголт байгааг тайлбарласан.

- НАТО-д элсэх хаалгыг нэгмөсөн хаах;
- НАТО-д элсэх хаалгыг одоо онгойлгох;
- эсвэл эхний хоёр хувилбарыг нээлттэй байлгах (Ultsch 2010-ыг үзнэ үү).

Финляндын тухайн үеийн Засгийн газар гурав дахь хувилбарыг сонгосноор НАТО-д элсэх хаалга нь нээлттэй байгаа юм. Одоогоор Финлянд НАТО-гийн гишүүн болох цаг нь болоогүй байна. Үүний тулд иргэд, парламент, улс төрийн элитүүдийн олонх уг алхмыг дэмжих ёстой. “Бид гадаад бодлогоо НАТО-той уялдуулах, НАТО-той аль болохоор нягт хамтран ажиллахыг хичээх хэрэгтэй” гэж Стубб хэлсэн юм (Ultsch 2010).

НАТО-гийн гишүүн байхын давуу тал нь аюулгүй байдлаа

12 Энэ санал асуулгаар иргэдийн 57 хувь нь ЕХ-г хүлээн зөвшөөрч 43 хувь нь татгалзсан. Орон нутгийн иргэд бараг бүгд ЕХ-ноос татгалзсан бол Хельсинкийн оршин суугчдын 74 хувь нь тийм гэж хариулсан байна (Visu- ri/Paavonen: 2000: 250).

13 “Европын аюулгүй байдлын хөгжил ба Финляндын батлан хамгаалах” талаарх 1997 оны 3 дугаар сарын 17-нд Парламентад тавьсан Төрийн Зөвлөлийн тайлангаас ишлэв. (Möttölä 2005: 18).

нэмэгдүүлэх болон аюулгүй байдлын асуудлаарх шийдвэрт нөлөөлөх боломж гэж Стубб үзсэн байна. Тухайн үед Орост НАТО-той аль болох ойртон нягтрахад нь дэмжлэг үзүүлэхийг Финлянд эрмэлзэж байлаа. Үүний нэг жишээ нь 2010 оны 5 дугаар сарын 6-нд *НАТО-Оросын зөвлөлөөс* НАТО, Оросын цэргийн хамтын ажиллагааг 2011 он хүртэл "өндөр түвшинд гаргах"-д бэлэн байгаагаа илэрхийлсэн явдал юм (Ultsch 2010). НАТО-гийн Афганистан руу илгээсэн Аюулгүй байдлыг хангах олон улсын хүчинд *(International Security Assistance Force – ISAF)* Финлянд хувь нэмрээ оруулсан бөгөөд Стубб энэ ажиллагаанд оролцсон үндэслэлээ олон улсын өмнө хүлээсэн үүргээ ухамсарлах, хар тамхины наймаатай тэмцэх (Европ руу нэвтэрч буй хар тамхины ихэнх нь Афганистанаас ирдэг ажээ), терроризмыг дарах явдал хэмээн тайлбарласан (Ultsch 2010-ыг үзнэ үү).

ОХУ-ын Ерөнхий сайд Дмитрий Медведев хэлэхдээ "хэдийгээр Швед, Финляндын НАТО-д нэгдэн орох хэтийн төлөвлөгөө нь "тэдний дотоод хэрэг" боловч НАТО Оросын хилд тулж ирэх нь манай улсын хувьд эерэг зүйл гэж бид үзэхгүй байна" гэжээ (Ria Nowosti 2013). Медведев ийм дүгнэлт хийх болсон шалтгаанаа "НАТО бол таагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд ОХУ-ын эсрэг хэрэглэж болох "дайн хийх хүчин чадалтай бүтэц юм" хэмээн тайлбарласан байна. Оросуудын үзэж буйгаар Финлянд, Швед эвсэлд элссэн тохиолдолд юуны түрүүнд Баренцын тэнгисийн бүсэд хүчний тэнцвэрт өөрчлөлт гарах гэнэ (Ria Nowosti 2013-ыг үзнэ үү).

2014 оны 4 дүгээр сарын эхэнд Финляндын Ерөнхийлөгч асан, Нобелийн шагналт Мартти Ахтисаари *(Martthi Ahtisaari)* Украины хямрал, өрийн хямрал улам өсөн нэмэгдэж байгаа, дэлхийн санхүүгийн зах зээл итгэхэд бэрх болсон зэрэгтэй уялдан Финлянд Шведтэй хамт НАТО-д нэгдэх хэрэгтэй гэсэн байдаг. Хоёр орны Засгийн газрын гишүүд, түүний дотор тухайн үеийн Финляндын Гадаад хэргийн сайд Эркки Туомиоаа *(Erkki Tuomioja*), Шведийн тухайн үеийн Ерөнхий сайд Фрэдрик Райнфэлд *(Fredrik Reinfeldt)* нар НАТО-гийн талаар нухацтай хэлэлцүүлэг хоёр оронд явуулахаас татгалзсан юм. Хоёр орны иргэдийн дийлэнх нь урьдын адил НАТО-д элсэх асуудалд болгоомжтой ханддаг (Die Presse 2014d-г үзнэ үү). 2012 оны 7 дугаар сард тухайн үеийн ОХУ-ын Жанжин штабын дарга Николай Макаров Хельсинкэд албан ёсны айлчлал хийх үеэрээ Финлянд НАТО-г сонгосон тохиолдолд "улс төр, эдийн засгийн хүндхэн үр дагавартай" тулгарч болзошгүйг анхааруулжээ (O´Dwyer 2013: 15-ыг үзнэ үү).

2014 оны 3 дугаар сард Крымд санал асуулга явуулж, тус хойгийг Украинаас салган тусгаарласныг Финлянд *хууль бус* үйлдэл гэж үзсэн.

Үүнтэй уялдан 2014 оны 3 дугаар сарын 18-нд тухайн үеийн Ерөнхий сайд Юурки Катайнен *(Jyrki Katainen)* "Финлянд бол эвсэлд үл нэгдэх орон, "төвийг сахисан улс биш" гэж онцлон хэлсэн юм (O´Dwyer 2014b: 6-г үзнэ үү). Финляндын Батлан хамгаалахын сайд Карл Хаглунд *(Carl Haglund)* Крым, Украинд болж үйл явдал, түүний Европын аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөний талаар сэтгэл зовниж байгаагаа мэдэгдсэн (Bigalke 2014: 7-г үзнэ үү). Тэрээр "Оросууд өөрийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд цэргийн хүч хэрэглэж байгаа нь тун харамсалтай" гээд Финлянд Крымийн хямралыг дипломат арга замаар шийдэхийн төлөө, "ЕХ-ноос гаргасан шийдвэрийн ард баттай зогсохоо" илэрхийлсэн байдаг (Bigalke 2014: 7). Оросын ойрын хөршийн хувьд Финлянд ОХУ-тай бүх шатны бодит харилцаагаа өнөөгийн нөхцөлд ч гэсэн хөгжүүлэх шаардлагатай аж (Bigalke 2014: 7). Тухайлбал, Финлянд байгалийн хийгээ 100 хувь Оросоос авдаг (Bigalke 2014: 7-г үзнэ үү).

НАТО-гийн түнш Швед, Финлянд хоёр *Харилцан батлан хамгаалах тухай гэрээг* 2014 оны тавдугаар сард байгуулсан. Тиймээс хамтдаа НАТО-д нийцэх тоног төхөөрөмж авахаар болжээ (O´Dwyer/Adamowski 2014: 14). Украины хямрал, улс орны дотоод хэрэгт оролцож буй Оросуудын үйлдэл нь Финлянд, Шведийн НАТО-гийн гишүүн болох цагийг урьд урьдаас илүү ойртуулсан талаар Батлан хамгаалахын сайд Карл Хаглунд хэлэхдээ: „Энэ нь анхнаасаа Оросын зорилго байсан эсэхэд би эргэлзэж байна"(O´Dwyer/Adamowski 2014: 14-ийг үзнэ үү) гэв. НАТО онцгой байдалд Финляндыг хурдан шуурхай хамгаалах боломж олгох тусгай гэрээ хийхээр төлөвлөж байна. Харин Финлянд тухайн цэргийн анги нэгтгэлийг тээврийн хэрэгсэл, байр сууцаар хангахад бэлэн байх үүрэг хүлээх аж. Энэ талаар 2014 оны 4 дүгээр сарын 22-нд *Харилцан ойлголцлын санамж бичигт (MoU)* гарын үсэг зурсан байна (Deutsche Wirtschaftsnachrichten 2014-ийг үзнэ үү). Үүнээс 5 жилийн өмнө 2009 оны 6 дугаар сарын 9-нд НАТО-гийн Зөвлөгөө, удирдлага, хяналтын агентлаг (*Consultation, Command and Control Agency- NC3A)* болон Финляндын хооронд батлан хамгаалах технологийн салбарын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан. НАТО-той ийм төрлийн гэрээ хийсэн анхны түнш улс нь Швед бөгөөд 2007 онд энэ гэрээг байгуулсан байдаг (NATO 2009-ийг үзнэ үү).

Финлянд кибер аюулгүй байдал, онгоцыг агаарт цэнэглэх болон нисгэгчгүй онгоц зэрэг тээврийн салбарт Европын түвшинд хамтран ажиллахыг хичээдэг.

„НАТО түншлэгч орнуудаа санал болгодог Энхийн төлөө түншлэлийн төлөвлөлт, хяналтын процесс (PARP) нь Финляндын хувьд хамгийн чухал арга

хэрэгсэл юм. Энэ нь Финляндын батлан хамгаалах чадавх, харилцан ажиллах чадварыг нэмэгдүүлдэг. Батлан хамгаалах стандарт, чадавхын шаардлагын эх сурвалж гэдэг утгаараа НАТО Финляндад онцгой чухал ач холбогдолтой.“ (Partanen 2013: 112f.).

Финлянд Шведийн нэгэн адил НАТО-гийн өндөржүүлсэн бэлэн байдлын хүчинд *(NRF)* хамрагддаг. 2012 онд Финлянд хими, биологи, цацраг, цөмийн бодисоос хамгаалах ажиллагааны зөөврийн лабораторитой (50 шинжээчтэй) оролцсон ба 2013 онд тусгай хүчний нэг групп нь *NRF-д* хамрагдсан. 2014 онд *F-18* сөнөөгч нисэх онгоцтой байлдааны нэгжийг *NRF-н* хэрэгцээнд гаргаж өгчээ (Partanen 2013: 113 үзнэ үү). Гэхдээ Финлянд Оростой нягт харилцаатай байдаг. 2014 оны байдлаар Финляндын гадаад худалдаанд Германы дараа орох том түнш нь ОХУ байв (Partanen 2013: 113 –ыг үзнэ үү). 2013 онд Оросууд батлан хамгаалахын салбарт *урт хугацааны түнш* болохыг Финляндад санал болгосон байдаг. Ингэснээр байлдааны танк, агаараас хамгаалах систем, нисэх онгоц зэрэг Финляндын зэвсэгт хүчний зэвсэглэлийн ихэнхийг Москва нийлүүлэх боломжтой болох байсан (Defense News Staff 2014: 8-ыг үзнэ үү). Үүнээс гадна Оросын батлан хамгаалах салбарын зах зээлд орох боломжийг Финляндын компаниудад нээж өгөхөд бэлэн байсан юм (Defense News Staff 2014: 8-ыг үзнэ үү). Одоогийн байдлаар яриа хэлэлцээ зогсонги байдалтай байна. „Хэн ч хориг тавихыг хүсэхгүй, тэгэх ч сонирхолгүй, гэвч энэ бол Оросын өөрөө бий болгосон хямрал“ хэмээн Финляндын Ерөнхий сайд Александр Стубб цохон тэмдэглэжээ (Defense News Staff 2014: 8-ыг үзнэ үү).

## 7.3 Ирланд

Ирланд *төвийг сахих* болсон нь гагцхүү цэргийн шалтгаантай байсан: „Ирландын цэргийн төвийг сахих бодлогыг тодорхойлох гол шинж нь цэргийн эвсэлд үл нэгдэх явдал юм“ (McBean 2005: 25). 1921 оны 12 дугаар сарын *Англи-Ирландын гэрээ* нь орчин цагийн Ирланд улсын анхны төрийн тогтолцооны үндэс болж өгсөн хэдий ч Их Британийн *Хатан хааны цэрэгт* Ирландын нутаг дэвсгэр дээрх тэнгисийн цэргийн гурван баазыг ашиглах эрх олгосон байжээ. Энэ эрх нь Ирланд-Британийн 1938 оны хэлэлцээр хүртэл хүчинтэй байв (Elvert 2000: 192-ыг үзнэ үү). 1932-1938 оны *Фианна Файлын (Fianna Fáil)* Засгийн газар Ирланд дахь Британийн нөлөөг нэлээд бууруулсан юм. 1937 онд тус улс тусгаар

тогтнолоо олж авснаас эхлэн төвийг сахих чиг баримжаатай болсон бөгөөд Умард Ирландын зургаан тойрог Нэгдсэн Вант Улсаас цэргийн хараат байхыг эсэргүүцсэн юм. Дэлхийн II дайны үеэр Ирланд улс төвийг сахихаа зарласан агаад түүнээс хойш өнөөг хүртэл төвийг сахих байр суурь гадаад бодлогын тулгын чулуу хэвээр үлдсэн (Girvin 2000: 89 үзнэ үү). Ирланд 1949 он хүртэл Хамтын нөхөрлөлийн орнуудын нэг байсан: „Бодит байдал дээр энэ нь утга багатай зүгээр л албан ёсны харилцаа байсан" (Girvin 2000: 89). Ирландыг хуваасныг хүлээн зөвшөөрсөнтэй адил болох байсан тул дэлхийн II дайны дараа Ирландын Засгийн газар НАТО-гийн гишүүн болохоос татгалзсан (Hauser 2002: 61). Ийнхүү Их Британичууд арлыг хуваасантай холбоотой зөрчилдөөнөөс Ирландын төвийг сахих бодлого бий болжээ.

Ирланд 1945 онд эвсэлд үл нэгдэхээ зарлаж, 1948 онд Маршаллын төлөвлөгөөнд хамрагдсан орны хувьд Швед, Швейцарь, Австрийн нэгэн адил *Европын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад* элсжээ. Энэ байгууллага хожим буюу 1960 онд АНУ, Канад гишүүнээр элссэний дараа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага *(OECD)* болсон билээ. 1947 онд Ирландыг НҮБ-д элсэхэд ЗХУ саад хийсэн хэдий ч Зөвлөлтийн Өрнөдтэй энх тайвнаар зэрэгцэн орших стратегиас үүдэн 1955 онд НҮБ-ийн гишүүнчлэлийг нь хүлээн зөвшөөрсөн юм (Hauser 2002: 61): „Ирландын төвийг сахих бодлого Америкийн талыг баримтлах үзлээс ихээхэн хамаарч байсан, ялангуяа тус улсыг НҮБ-д элссэний дараа энэ хамаарал улам нэмэгдэв" (Girvin 2000: 98). Их Британийг бодвол Ирланд хэзээ ч *Европын чөлөөт худалдааны нийгэмлэгийн (EFTA)* гишүүн болоогүй ч Засгийн газар нь *Европын нийгэмлэгт (EG)* элсэхийг үгүйсгэж байгаагүй. Засгийн газрын үзэж байгаагаар, Ирланд ийм төрлийн гишүүнчлэлийн талаар ярих гол угтвар нөхцөл нь Британи Европын нийгэмлэгт нэгдэх явдал байлаа. Ингээд НАТО-гийн 6 орноос анхлан бүрдэж байсан Европын нийгэмлэгт 1973 онд Ирланд төвийг сахисан анхны гишүүн болж, Дани, Их Британийн хамт тус нийгэмлэгт нэгджээ. Ирландын Засгийн газар анх 1961 онд Европын нийгэмлэгт элсэх хүсэлтээ гаргасан байдаг (Hauser 2002: 63-ыг үзнэ үү). Ирланд эхлээд Европын нийгэмлэгт, дараа нь Европын холбоонд *цэргийн төвийг сахих* байр суурь барихаа мэдэгдсэн хэдий ч *ЕХ-ны талаарх 1992 оны 2 дугаар сарын 7-ны Маастрихтийн гэрээ*, түүнтэй холбоотой гаргасан Гадаад бодлого, аюулгүй байдлын нэгдсэн бодлого *(GASP),* 1999 оны 7 дугаар сард гаргасан *Европын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого (ESVP),* 2009 оны 12 дугаар сард *Лиссабоны гэрээнд* баталгаажсан Хамтын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого зэрэг нь хамаагүй зүйл биш юм: „Гэсэн хэдий ч,

Ирландыг ‚байнга төвийг сахисан’ эсвэл ‚төвийг сахисан улс’ гэж үзэх нь өөрөө маргаантай асуудал юм […]“ (McBean 2005: 25).

Ирландын төвийг сахих бодлого ямар ч олон улсын гэрээгээр баталгаажаагүй бөгөөд дотооддоо үндсэн хууль, бусад хууль эрх зүйн үндэслэл гаргаагүй байдаг (McBean 2005: 25-ыг үзнэ үү). Дийлэнх Ирландчууд төвийг сахих байр сууриа хадгалахыг дэмждэг (McBean 2005: 25-ыг үзнэ үү). 1992 оны 4 дүгээр сард Ирландын Засгийн газраас гаргасан *Цагаан номонд “Европын холбооны тухай гэрээ” гарчигтайгаар* Маастрихийн гэрээний дагуу Холбоо байгуулах явцад гаргасан ЕХ-ны аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого нь “Ирландын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, өөрөөр хэлбэл, төвийг сахисан бодлогод хохирол учруулахгүй. […] Энэхүү гэрээгээр Ирланд харилцан батлан хамгаалах үүрэг хүлээх заалтгүй бөгөөд Ирланд цэргийн эвсэлд нэгдэх үүрэг хүлээхгүй” гэсэн заалт байдгийг оруулж өгчээ („Ирландын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого өөрөөр хэлбэл, төвийг сахисан бодлогод хохирол учруулахгүй. […] Энэхүү гэрээнд Ирланд харилцан батлан хамгаалах үүрэг хүлээх заалт ороогүй бөгөөд Ирланд цэргийн эвсэлд нэгдэх үүрэг хүлээхгүй” (Girvin 2000: 108). Үүнийг ерөнхийдөө *Ирландын заалт* гэж ойлгодог.

2002 онд тухайн үеийн Ерөнхий сайд Берти Ахерн *(Berthie Ahern)* Засгийн газрынхаа даалгавраар *Ниццагийн гэрээгээр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуух ЕХ-ны гэрээтэй* холбогдуулан 2002 оны 6 дугаар сарын 21-нд гаргасан тунхаглалд тухайн үеийн ЕХ-ны гишүүн (15 гишүүн) орны зүгээс Ирландын цэргийн төвийг сахисан байр суурийг баталсан байна.

Севильед болсон Европын Зөвлөлийн хурлаас гаргасан хавсралтын III ба IV-д бас тусгагдсан энэ тунхаглалын зорилго нь 2002 оны 10 дугаар сарын 19-нд Ирландын иргэдээр *Ниццагийн гэрээний талаарх* хоёр дахь санал асуулга явуулж дэмжүүлэх, ЕХ армитай болох вий гэсэн Ирландын ард иргэдийн айдсыг намжаахад оршиж байлаа. Тус тунхаглалд Гадаад бодлого, аюулгүй байдлын нэгдсэн бодлого нь Ирландын “цэргийн төвийг сахих уламжлалт бодлогыг хөндөхгүй” гэдгийг тусгаж өгчээ (Hauser 2002: 64-ийг үзнэ үү). Энэ хэсэг нь бүр 1992 оны *Маастрихтийн гэрээнд Ирландын заалт нэртэй* J.7-р бүлэгт тусгагдсан байсан ЕХ-ны гэрээнээс урган гарсан юм. Тухайлбал, ЕХ-ны бодлого “аль нэг гишүүн орны аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлогын онцлог шинжийг хөндөхгүй” гэсэн байдаг. Цэргийн төвийг сахих байр суурьтай уялдан Ирланд хамтын батлан хамгаалах тухай гэрээнд хамрагдахгүй бөгөөд Европын армийг хөгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг биш юм. „Ингэснээрээ Ирландын төвийг сахих уламжлалт

бодлогод нөлөөлөхгүй болно“ (McBean 2005: 31).

Энэхүү ирландын заалт нь Ирландын “төвийг сахих бодлогын дархлааны заалт” болдог (Hummer 2001: 151-ийг үзнэ үү). Цаашид НҮБ-ын мандаттай ЕХ-ны хямралыг зохицуулах ажиллагаанд Ирланд оролцоход бэлэн агаад зарчмын хувьд Ирландын Засгийн газар, Парламент (Ирландын Парламентын доод танхим, *(Dáil Éireann)*) шийдвэр гаргаснаар бусад ЕХ-ны гишүүн орны нэгэн адил Гадаад бодлого, аюулгүй байдлын нэгдсэн бодлогын дагуу ажиллагаанд оролцох бололцоотой болно. Парламентын гишүүн Брайан Кроулийн *(Brian Crowley)* хэлснээр *ЕХ-ны Лиссабоны гэрээний* талаарх санал асуулгын кампанит ажлын үеэр ирландын олон иргэн уг *гэрээ* Ирландын төвийг сахих бодлогыг үгүй хийнэ гэж санаа зовниж байжээ. 2009 оны 7 дугаар сард ЕХ-ны төр, засгийн тэргүүнүүд Ирландын аюулгүй байдал, батлан хамгаалах асуудалд дараах байдлаар хууль эрх зүйн баталгаа өгөхөөр санал нэгдсэн:

„Лиссабоны гэрээнд Европын арми байгуулах, цэрэг татлагын тухай тусгагдаагүй. Лиссабоны гэрээ Ирланд болон ЕХ-ны бусад орны аюулгүй байдал, батлан хамгаалахдаа зарцуулах зардлын хэмжээ, хэлбэрээ тодорхойлох эрхэд нь ямар ч нөлөө үзүүлэхгүй “ (Crowley 2014).

Ирландын Евро-парламентын депутат Пэт Галлахер *(Pat the Cope Gallagher- Fianna Fail)* “Энэхүү эрх зүйн баталгааны гол санаа нь өөр хэн ч биш Ирланд улс л батлан хамгаалах бодлогын асуудлаа шийдвэрлэнэ гэсэн үг” гэдгийг тодотгосон байна (Crowley 2014). Ирландуудын үзэж байгаагаар „Лиссабоны гэрээгээр Ирландын төвийг сахих байр суурь бүрэн хамгаалагдсан“ (Crowley 2014) юм.

Тус улсын том намууд *Фианна Файл, Синн Файн (Fianna Fail, Sinn Fein)* төвийг сахихаа хэвээр хадгалах нэгдмэл байр суурьтай байдаг. Харин сөрөг хүчин болох *Фина Гаэл (Fine Gael*) нам Ирландыг төвийг сахисан улс биш, харин „төвийг сахисан төдий“ гэж үздэг (Keatinge 2005: 33). Ирландын иргэдийн олонх нь дэмжээгүй цагт ЕХ-ны батлан хамгаалах бүтцэд оролцохгүй хэвээр байх болно. Энхийг дэмжих шаардлага гарвал урьдын адил Ирландын Засгийн газар, Парламент *(Ирландын Парламентын доод танхим, Dáil Éireann)* цэрэг илгээх талаар шийдвэр гаргах үүрэгтэй. Түүнчлэн НҮБ-ын мандат шаардлагатай (Crowley 2014). Ирландын төвийг сахих байр суурийг “байнгын” гэхээс илүүтэй “Умард Ирландтай дахин нэгдэх хүртэл түр зуурынх” гэдгээр ойлгох нь зөв юм (Goetschel 2000: 361).

## 7.4 Мальта улс

Арлын орон Мальта төвийг сахих болсон нь тухайн үеийн Ерөнхий сайд, *Хөдөлмөрийн намын* Дом Минтоффтой *(Dom Mintoff)* холбоотой. Тэрээр 1980 онд Италитай төвийг сахих тухай гэрээ байгуулсан бөгөөд өмнөх жил нь Италитай хамтран Мальта дахь Британийн сүүлчийн цэргийн баазыг хаасан байдаг. Минтофф 1979 оны 3 дугаар сард Мальтын төвийг сахих үзэл баримтлалыг боловсруулсан. Ирээдүйд Мальтын баримтлах төвийг сахих бодлогыг хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор бүр 1976 оноос эхлэн Итали, Франц, Ливи, Алжиртай хэлэлцэж эхэлжээ (Trigona 2010-ыг үзнэ үү). Мальта 1964 оноос хойш *Англи-Мальтын харилцан батлан хамгаалах хэлэлцээрийн* дагуу цэргийн асуудлаар Их Британитай холбоотой байдаг. Дом Минтоффын зорилго нь Их Британиас батлан хамгаалах асуудлаар хамааралгүй болж, төвийг сахигч болох явдал байсан бөгөөд тухайн үеийн Италийн Ерөнхий сайд Алдо Моро *(Aldo Moro*) үүнийг нь дэмжжээ (Trigona 2010-ыг үзнэ үү). Ялангуяа Моро дээрх санааг хэрэгжүүлэхийн тулд НАТО-г татан оролцуулж, 1972-1979 онд НАТО-гийн ашиглаж байсан Британийн цэргийн баазыг хаах тухай гэрээг Лорд Каррингтонтой *(Lord Carrington)* хийх хүртэл Минтоффыг дэмжиж байсан бөгөөд цаашлаад Мальта дахь уг бааз хаагдахад нөлөө үзүүлсэн юм (Trigona 2010-ыг үзнэ үү). Мальтад байрладаг Их Британийн цэргийн баазын түрээс 1972 оноос 1979 он гэхэд жилд 32,5 сая евро болж өссөн байна (Trigona 2010-ыг үзнэ үү). 1974 онд Британийн *Хамтын нөхөрлөлийн хүрээнд* төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байх Бүгд Найрамдах улсаа зарласан.

1978 онд Моро алагдаж, *Христийн ардчилсан нам* болон *Коммунист намын* төв байрны яг дунд зогсож байсан машины тээшнээс шарил нь олдсон ч Францын дэмжлэгтэйгээр Мальта, Италийн хооронд хэлэлцэж байсан төвийг сахих тухай хэлэлцээрийг үргэлжлүүлжээ (Trigona 2010-ыг үзнэ үү). Ингээд 1980 оны 9 дүгээр сарын 8-нд Итали нот бичгээр Мальтын төвийг сахих байр суурийг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү гэрээгээр нэн шинэ түүхэнд анх удаа Итали, Мальтын харилцаа ийнхүү тогтворжив (Trigona 2010-ыг үзнэ үү). Төвийг сахих тухай гэрээ Ерөнхий сайдын *Валлета дахь албаны өргөө Ауберге де Кастиллед (Auberge de Castille in Valetta)* Ерөнхий сайд Дом Минтофф болон Италийн Гадаад хэргийн яамны *Фарнезина ордонд (Palazzo della Farnesina)* Гадаад хэргийн сайд Емилио Коломбо *(Emilio Colombo)* нар тус тус гарын үсэг зурснаар 1980 оны 9 дүгээр сарын 15-нд албан ёсоор баталгаажсан (Trigona 2010-ыu үзнэ үү). Төвийг сахих тухай гэрээний

5-р заалтад Мальта улсад түрэмгийлсэн тохиолдолд, эсвэл тусгаар тогтнол, бие даасан, төвийг сахисан байдал, эв нэгдэл, арлын улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд эрсдэл учирвал, эсвэл НҮБ-ын Дүрмийн 51 дүгээр зүйлийг үндэслэн Мальта улс өөрийгөө хамгаалах шаардлага гарвал Италийн зүгээс цэргийн тусламж үзүүлэхээ баталсан байна. Арван жилийн дараа төвийг сахих тухай тунхаглал Мальта улсын Үндсэн хууль болон Төвийг сахих тухай гэрээний Италийн хэсэгт бүртгэгдсэн байна.

Мальта 1995 онд *НАТО-гийн Энхийн төлөө түншлэлийн* (*PfP)* гишүүн болсон бол оролцогч орон болохын өмнөхөн 1996 онд үүнийгээ цуцалжээ. Мальта *Энхтийн төлөөл түншлэл* дэх оролцоогоо 2008 оны 4 дүгээр сард сэргээсэн.

„Энхийн төлөө түншлэл нь Мальта улсын төвийг сахих байр суурьтай нийцнэ. Энхийн төлөө түншлэлийг Европ, Евро-Атлантын аюулгүй байдлыг нэмэгдүүлэх нэг хэрэгсэл гэж Мальта улс үздэг" (NATO 2014b-ийг үзнэ үү).

Мальта улс Энхийн төлөө түншлэлийн хүрээнд иргэн-цэргийн зохицуулалт, иргэний батлан хамгаалах салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг хичээдэг ( NATO 2014b-г үзнэ үү). Мальтын Гадаад хэргийн сайд Жорж Валла *(George Valla*) 2014 оны 3 дугаар сард хэлсэн үгэндээ 1980 онд Мальт улс Үндсэн хуулиндаа төвийг сахих тухай оруулсан үеэс хойш дэлхий ертөнц ихээхэн өөрчлөгдсөн талаар тэмдэглэжээ. Иймээс төвийг сахих нь „хэн ч, хэзээ ч бидэнд хүрч чадахгүй" гэсэн мэдрэмжийг илэрхийлэх ёстой (Malta Independent 2014) гэв. Гэхдээ зарим тодорхой аюул заналын үед төвийг сахих байдал нь цуцлагддаг байна. Тухайлбал террорист бүлэглэл гэж үздэг *Аль-Каида,* "Исламын улс" мэтийн тодорхой нэг заналхийллийн үед ийм төвийг сахих байдал үгүй болох аж: „Ялангуяа энэ бүлэглэл нь Ливийн ойролцоо газраар нэвтрэх төлөвлөгөөтэй. Бусад улс оронтой харьцуулахад Мальта өөрийгөө хамгаалах арга хэрэгслээр дутмаг юм" (Malta Independent 2014) гэв.

# 8. Серб, Молдав улсууд төвийг сахигч мөн үү?

Серб улс 2006 оны 12 дугаар сарын 14-нд *НАТО-гийн Энхийн төлөө түншлэлд* оролцогч болсон. Сербийн цэргийн төвийг сахих байр сууриа Бүгд Найрамдах Серб улсын Үндэсний ассамблейгаас 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гаргасан тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Үндсэн хуулийн байгуулалтын асуудлыг тусгасан тогтоолд дараах байдлаар тайлбарласан:

„НҮБ-ийн АЗ-ийн тогтоолгүй 1999 онд Сербийг хууль бусаар бөмбөгдсөнөөс эхлээд бие даасан Косовад төр засгийн эцсийн төлөөлөл нь НАТО байх нөхцлийг агуулсанаас болж хэрэгжиж чадаагүй Ахтисаари төлөвлөгөөний XI хавсралт гэх зэрэгт бүхэлд нь гүйцэтгэсэн НАТО-гийн үүрэг оролцооны улмаас Бүгд Найрамдах Серби улсын Үндэсний Ассамблей нь тулгамдаж буй асуудлуудыг эцсийн байдлаар шийдэж, шинэчлэл хийх хүртэл цэргийн эвслүүдэд цэргийн төвийг сахих байр суурь баримтлахаа зарласан билээ“ (Litavski 2012: 2).

Уг тогтоолыг Парламент дахь ихэнх том намууд баталсан хэдий ч *Либерал демократ нам, Социалдемократ лигийн* зүгээс эсрэг санал өгсөн бол *Унгарын Воеводины лиг* түтгэлзсэн байна (Litavski 2012: 1-ийг үзнэ үү). Сербийн *Үндэсний батлан хамгаалах стратеги* 2009 оны 4 дүгээр сард, *Үндэсний аюулгүй байдлын стратеги* 2009 оны 10 дугаар сард тус тус батлагдсан боловч өмнө нь баталсан цэргийн төвийг сахих бодлогыг дахин боловсруулаагүй, ямарваа нэгэн байдлаар дурдаа ч үгүй байна (Litavski 2012: 2-ыг үзнэ үү). Ийнхүү Сербийг одоогоор сайндаа л *эвсэлд үл нэгдэх* байр суурьтай гэж үзэхээс бус төвийг сахих тухай нэг талын мэдэгдэл гаргахад төвийг сахисан гэж хүлээн зөвшөөрөгдөхгүй юм (Litavski:1-ийг үзнэ үү). 2007 оны төгсгөлд төвийг сахих мэдэгдэл гаргасан нь Сербууд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа хадгалах, үүнийгээ Косовотой хамтран хэрэгжүүлэх ёстой гэж үздэгтэй холбоотой байж магадгүй юм. 2009 онд гаргасан Бүгд найрамдах Серб улсын Үндэсний аюулгүй байдлын стратегид:

„Дэлхийн өнөөгийн хурцдмал байдалд Бүгд Найрамдах Серби улс газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах асуудалтай тулгардаг. Энэ нь өмнөд бүс нутгийн Косово, Метохижа /Metohija/-гийн Косовогийн Албани угсаатны бүлэг дангаар, хууль бус байдлаар тусгаар тогтнолоо зарласантай холбоотой. Косово тусгаар тогтнолоо дангаараа зарласан нь үндэстний цөөнхийн эрх ашгийг хангахын тулд олон улсын хууль эрх зүйд харшилсан, НҮБ-ын гишүүн орнуудын хүсэл зоригийн эсрэг тэднийг хуваах гэсэн оролдлого юм“ (Tadić 2010: 3) гэжээ.

Түүнчлэн Сербийн төр засаг, ард иргэдийн баримталж буй байр суурь нь Зүүн Өмнөд Европын тогтвортой байдлын нэг гол хүчин зүйл болж байгаа гэдэгт тэд бүрэн итгэлтэй байдаг (Tadić 2010: 3-ыг үзнэ үү). *НАТО-гийн Энхийн төлөө түншлэлийн* оролцогч, ЕХ-нд нэр дэвшигч орны хувьд 2014 оны 1 дүгээр сарын 21-нд Серби ЕХ-нд элсэх яриа хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн. Серби улс Өрнөдийн Евро-Атлантын аюулгүй байдлын тогтолцоо, эдийн засгийн бүтэцтэй нягт холбоотой (Tadić 2010: 3-аас хойш үзнэ үү). Түүнчлэн 2009 оны Сербийн аюулгүй байдлын стратегид:

„ЕХ-нд элсэх болон бүс нутагт байр сууриа бэхжүүлэхтэй уялдан хоёр талын харилцааг хөгжүүлэх үйл явцыг цаашид үргэлжлүүлэх нь Бүгд Найрамдах Серби улс-ОХУ-ын онцгой харилцааны шинэ чиглэлийг бий болгох үндэс болно“ (Republic of Serbia 2010: 24) гэсэн байна.

2014 оны 3 дугаар сард Крымийг Оросууд авсны дараа Украины газар нутгийн бүрэн бүтэн байдлын асуудлаарх НҮБ-ын санал хураалтад Серб түтгэлзсэн юм. Серб ЕХ-ны нэр дэвшигч хэрнээ ийм үйлдэл хийхэд ЕХ-ны зүгээс шүүмжилсэн байна (The Economist 2014: 19-ийг үзнэ үү). Сербийн засгийн газар Косово бол Сербийн нэг хэсэг байх ёстойн нэгэн адил Крым Украины нэг хэсэг мөн гэж үзсэн. Оросын талыг баримтлагч, Зүүн Украины салан тусгаарлагчдыг дэмжих зорилготой дайчдыг зуучилдаг Сербүүдийн цахим хуудсанд Украины оросууд амьдардаг хэсэг буюу *шинэ Оросыг чөлөөлөөгүй* бол Косовог *чөлөөлөх* боломжгүй гэж онцлон тэмдэглэсэн байдаг (Economist 2014: 19-ийг үзнэ үү). Украины хямралаас үүдэн 2014 оны зун ОХУ-д хориг тавьсны дараа 2014 оны 8 дугаар сарын 3-нд ОХУ-ын Элчин сайд Константин Косачев Белградын *“Politika”* сэтгүүлд ярилцлага өгөхдөө ЕХ-ноос 2014 оны 7 дугаар сарын сүүлээр гаргасан эдийн засгийн хоригт[14] Серби улс нэгдвэл “Үндэсний онцлог, түүний бүрэн эрхт байдал, эдийн засгийн ашиг сонирхлоо алдах болно“ хэмээн хатуу анхааруулсан байдаг. Хэрвээ Серб цаашид ОХУ-ын талд зогсвол “5 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт болон газар тариалангийн бүтээгдэхүүний ихээхэн хэмжээний экспорт хийх боломж бүрдэнэ” гэжээ (Die Presse 2014b:5). Ийнхүү Серб улс “хуучин холбоотон Орос болон ЕХ-ны хооронд “тэлчилсэн” хэвээр байна” (The Economist 2014: 19).

14 Үүнд холбогдох Nr. 833/2014 тоот тогтоол 2014 оны 8 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Хөрөнгийн зах зээлийг хамарсан уг хоригоор Оросын банкууд, тэр дундаа төрийн өмчийн дийлэнх банкууд хязгаарлагдмал байдлаар Европын хөрөнгийн зах зээлд гарах болжээ. Түүнчлэн цэргийн болон давхар зориулалттай бараа бүтээгдэхүүний экспортод хориг тавьжээ ( Hecht 2014: 19-ийг үзнэ үү).

Сербийн Гадаад хэргийн сайд Ивица Дачич *(Ivica Dačić)* ЕХ-ны зүгээс Белградыг ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээнд нэгдүүлэх гэж даралт үзүүлдэг хэмээн шүүмжилжээ. Тэрээр Украины зүүн хэсэг дэх ЕАБХАБ-ын ажиглагчдын үйл ажиллагааг эрчимжүүлэхийг дэмждэг бөгөөд,

"Бид Украины газар нутгийн бүрэн бүтэн байдлыг дэмжиж, Крымийг өөртөө нэгтгэснийг нь хүлээн зөвшөөрөхгүй гэж байнга ярьдаг учраас Оросууд уурладаг. Нөгөө талаас бид Орост эдийн засгийн хориг тавиагүйгээс болж ЕХ бухимдалтай байдаг" гэж хэлсэн байна (Ultsch 2014: 6).

Сербуудын хувьд "Оросуудад хориг тавих нь эдийн засгийн амиа хорлолт болно. Бид Оросоос 100 хувь эрчим хүчний хамааралтай" хэмээн Дачич хэлжээ (Ultsch 2014: 6). Үүнээс гадна Серб 2014 онд эхэлсэн ЕХ-нд нэгдэх тухай яриа хэлэлцээнийхээ 31 дүгээр зүйлийг (гадаад бодлого, аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого) хэлэлцэж эхлээгүй байгаа юм. "Яриа хэлэлцээний үйл явцын хамгийн сүүлд бид гадаад бодлогоо ЕХ-ны чиг шугамтай бүрэн зохицуулсан байх ёстой" гэж Дачич цохон тэмдэглэсэн (Ultsch 2014: 6). Сербийн цэргүүд Оросын анги нэгтгэлтэй болон *НАТО-гийн Энхийн төлөөх түншлэлд* оролцогч орны хувьд аль алинтай нь хээрийн сургуулилт хийдэг юм (The Economist 2014: 19-ийг үзнэ үү).

*Молдав* байнга төвийг сахих бодлогын талаар Үндсэн хуулийнхаа 11 (1)-д „Бүгд Найрамдах Молдав улс нь байнгын төвийг сахихаа тунхаглаж байна" гэж заажээ (Presidency of the Republic of Moldova 2000). Түүнчлэн 11 дүгээр зүйлийн (2)-т „Молдав улс нутаг дэвсгэр дээрээ гадны цэрэг байрлуулахыг зөвшөөрөхгүй" гэж тодорхой тусгасан байдаг" (Presidency of the Republic of Moldova 2000). Гэсэн хэдий ч Молдавын төвийг сахих байр суурь олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй байна. Оросууд одоо хүртэл Молдавын Днестр мөрний зүүн хэсэг Транснистрийг эзлэн суурьшсан хэвээр байдаг. Бүр Зөвлөлтийн үеийн төгсгөлд 1990 оны 9 дүгээр сарын 2-нд *Транснистрийн Ардын депутатуудын Их хурлын Хөдөлмөрийн нэгдлийн Нэгдсэн зөвлөлөөс Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Молдав* улсыг үүсгэн байгуулахаар шийджээ. Үүнийг нь Кишинев болон Москвагийн аль аль нь хүлээн зөвшөөрөөгүй юм.

"Энэ нь Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Молдав улс болон ЗХУ-ын (Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс) үндсэн хуулийг зөрчсөн нь тодорхой байсан хэдий ч Москва үүний эсрэг алхам хийгээгүй" (Malek 2006: 7).

Москвад төрийн эргэлт хийх гэсэн оролдлого (1991 оны 08 дугаар сарын 19-нөөс 21-нд) бүтэлгүйтсэний дараа 1991 оны 8 дугаар сарын 25-нд *Транснистрийн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Молдав улс* нутгийн энэ хэсэг Молдаваас тусгаарлаж байгаагаа мэдэгдсэн тунхаглал гаргажээ. Үүнээс 2 хоногийн дараа Молдав задран унаж буй *ЗХУ-аас* салж, тусгаар тогтнолоо зарласан байдаг (Malek 2006: 7ff.). 1992 оны сүүлээр генерал Александр Лебедийн тушаалаар оросын 14-р армийн цэрэг Транснистрийн салан тусгаарлагчдын талд орж интервенц хийсэн. Тухайн үед Лебед "Танк хөдөлгөж хоёр өдрийн дотор Бухарестэд очиж чадна" хэмээн ил тод заналхийлж байжээ (Malek 2006: 11-ийг үзнэ үү). Одоо хүртэл Транснистрийг олон улсад хүлээн зөвшөөрөөгүй агаад олон улсын эрх зүйгээр Молдавын нэг хэсэг хэвээр байгаа гэж үздэг.

Дээрх маргаантай асуудалтай уялдан 1993 оноос эхлэн ЕАБХАБ-ын зүгээс Молдавт үйл ажиллагаагаа явуулж байна. Маргааныг зохицуулах зорилготой яриа хэлэлцээг 5+2 буюу ЕАБХАБ, ОХУ, Украин, АНУ, ЕХ оролцсон форматаар хийж байна (Munro 2010:10 үзнэ үү). Хэдийгээр 2006 онд энэ форматын яриа хэлэлцээ түр зогссон ч 2006 оны 9 дүгээр сард Транснистр тусгаар тогтнолын асуудлаар дахин санал хураахыг шаардаж, 2008 оноос эхлэн Оросууд зуучилсны дүнд 5+2 формат дахин сэргэсэн (BBC 2014). 2014 оны эхний байдлаар Транснистрт оросын 2000 орчим цэрэг байрлаж байна (Kashi 2014 үзнэ үү). 2014 оны 6 дугаар сарын 27-нд Молдав, Гүрж, Украин улс ЕХ-нд *нэгдэх үйл ажиллагааны эхлэл гэрээг* байгуулжээ.

„Зүүний түншлэлийн хүрээнд хийгдсэн хамтын ажиллагааны энэ гэрээнүүд нь ЕХ-той улс төр, эдийн засгийн харилцааг ихээхэн гүнзгийрүүлэх болно. Эдгээр гэрээнд Өргөжүүлсэн, иж бүрэн чөлөөт худалдааны бүс (DCFTA) мөн багтсан“ (European Union External Action Service 2014).

Молдав улс Украины нэгэн адил ЕХ-нд ойртон нягтрахыг эрмэлздэг. Молдавын Үндсэн хуульд зарлан тунхагласан, Транснистрийн хэсэгт мөн адил хамаарах төвийг сахих байр суурийг ОХУ-ын зүгээс хүлээн зөвшөөрөөгүй юм. Үүнээс болж Молдавт талуудын хооронд Транснистрийг тойрсон асуудлаар маргаан үргэлжилсээр байна.

# 9. Украин: онцгой тохиолдол

Украины Ерөнхийлөгч асан Леонид Кучма 2004 онд бүрэн эрхийн хугацаа дуусах хүртлээ нэг талаар улс орноо ЕХ, НАТО-д интеграцчилах, нөгөө талаар энэхүү үйл явцыг ОХУ-тай эдийн засаг, аюулгүй байдлаар интергацчилагдах бодлоготой хослуулах “савлуурын бодлого” явуулахыг хичээсэн юм. Кучма улс орноо олигархижсан ардчиллын замаар хөтөлснөөс хойш төр, бизнес хоёр салшгүй холбоотой болсон (Kowal/Wapinski 2014:10-ыг үзнэ үү). *Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн* (ТУХН) орнуудаас Украин улс хамгийн анх *НАТО-гийн Энхийн төлөө түншлэлийн* суурь баримт бичигт 1994 оны 2 дугаар сарын 8-нд гарын үсэг зурсан. 1997 оны 7 дугаар сарын 8-нд Мадридад болсон НАТО-гийн төр, засгийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтын үеэр Кучма *Умард Атлантын гэрээний байгууллага, Украины хоорондох өвөрмөц түншлэлийн тухай дүрэм* (*Charter on a Distinctive Partnership between the North Atlantic Treaty Organization and Ukraine)-д* гарын үсэг зурсан байна. Энэ баримт бичиг нь Украиныг НАТО-гийн гишүүнээр элсүүлэх хэтийн зорилго агуулаагүй бөгөөд НАТО-гийн зүгээс Украинд аюулгүй байдлын баталгаа өгөөгүй юм.

Украин улс НАТО-гийн Босни Герцеговина, Косовод явуулсан ажиллагаанд 1996 оноос эхлэн оролцож ирсэн. 2000 оны 7 дугаар сард Косовод явуулсан *KFOR-ын* ажиллагааны хүрээнд *украин-польшийн батальоныг (UKRPOLBAT)* илгээж, өнөөг хүртэл аюулгүй байдал болон хилийн хяналтын үүргийг гүйцэтгэж байна (Malek 2009: 527 үзнэ үү). Кучмаг залгамжлан гарч ирсэн Ющенко 2004-2010 онд Өрнөдтэй бүрэн интеграцчилагдах зорилготой ажилласан байдаг (Malek 2009: 516). Түүний сонгуулийн ялалт нь АНУ, ЕХ-ны улс төр, санхүүгийн дэмжлэгтэй хийгдсэн *улбар шар хувьсгалын* үр дүн байсан юм (Mearsheimer 2014: 77f-ийг үзнэ үү). Энэ хүрээнд *Дээд Рада* 2006 оны 10 дугаар сард *Стратегийн агаарын тээврийн тухай гэрээг* баталж, түүнээс хойш НАТО болон түншлэгч орнуудын цэргийн тээвэр, анги нэгтгэлийн шилжилт хөдөлгөөнийг гүйцэтгэх тээврийн *Антонов-124* мэтийн том онгоцыг Афганистан, Мали руу нислэг хийх зориулалтаар түрээслэх асуудал чөлөөтэй болсон. 2008 оны 4 дүгээр сарын 3-нд Бухарестад болсон НАТО-гийн дээд хэмжээний уулзалтаар Гүрж болон Украиныг гишүүнээр элсүүлэхийг дараах байдлаар амалсан байна:

„Украин, Гүржийн НАТО-гийн гишүүн болох гэсэн Евро-Атлантын хүсэл эрмэлзлийг НАТО талархан хүлээн авч байна. Өнөөдөр бид эдгээр улс орныг

НАТО-гийн гишүүн болгохоор тохиролцлоо” (NATO 2008: Punkt 23).

Бухарестын дээд хэмжээний уулзалтын дараа буюу НАТО-гийн зүгээс Украин, Гүржид дээрх амлалт өгснөөс хойш Гүрж-Оросын хооронд *Наймдугаар сарын дайн* болж, үр дүнд нь Абхаз, Өмнөд Осети мужууд Гүржээс салан тусгаарлаж, тэднийг бие даасан улс болсныг хүлээн зөвшөөрсөн.

1990 оны дунд үеэс эхлэн тухайн үеийн АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтон НАТО-г Зүүн Европ руу өргөжүүлэн тэлэх ажиллагааг эхлүүлсэн. Украин баруунжихыг Оросууд ихээхэн эсэргүүцэн хүлээн авчээ. Чикагогийн их сургуулийн улс төр судлаач Жон Мэаршаймер (*Жон Mearsheimer*) энэ талаар хэлэхдээ:

„1990 оны дундаас эхлэн Оросын удирдлагууд НАТО-гийн тэлэлтийг тууштай эсэргүүцэж байсан бөгөөд сүүлийн үед түүний зэргэлдээ стратегийн чухал хөршүүд НАТО-гийн цайз болохыг хараад сууж тэвчихгүй гэдгээ ил ойлгуулах болсон“ (Mearsheimer 2014: 77) гэжээ.

Оросууд Украиныг өөрийн нөлөөний бүс гэж үздэг. Оросын Ерөнхийлөгч Борис Ельцинээс эхлээд Владимир Путин хүртэл НАТО-г заналхийлэл (Malek 2009: 515f.) буюу Европ дахь АНУ-ын нөлөөг тэлэх, бэхжүүлэх улс төрийн зэвсэг гэж үздэг байна. „Улс орных нь ойролцоо аюул үүсч болзошгүй тохиолдолд их гүрнүүд үргэлж эмзэг ханддаг“ (Mearsheimer 2014: 82).

АНУ-ын стратегич Хенри Киссинжер, З. Бежинский нар 1995 оны 1 дүгээр сарын 1-нд Финлянд ЕХ-нд элсэхийн өмнөх үеийн *Финляндын загварыг* санал болгож: Украин ЕХ-той хамтран ажиллах бөгөөд харин НАТО-д элсэхгүй байх хэрэгтэй (Bigalke 2014: 7-г үзнэ үү) гэв. Украины 2014 оны шинэ Засгийн газрын анхны Гадаад хэргийн сайд Андрей Дещыция “Финляндын загвар Украины нэг хувилбар байж болох юм. ОХУ-ын хөрш, ЕХ-ны гишүүн, харин НАТО-гийн гишүүн биш” хэмээн мэдэгдэж байжээ (Ultsch/Schneider 2014-ийг үзнэ үү). Бүр 25 жилийн өмнө Украин улс *эвсэлд үл нэгдэх* статусаа зарлаж байжээ. 1990 оны 7 дугаар сарын 1-нд баталсан *Тусгаар тогтнолын тухай тунхаглалд* төвийг сахихын үндсийг тусгасан байв (Bigalke 2014:7). Үүндээ Украин улс байнга төвийг сахиж байхаа мэдэгдээд, ямар ч цэргийн эвсэлд нэгдэхгүй, цөмийн зэвсгээс ангид байхаа тунхагласан байдаг. 2010 онд Украины Ерөнхийлөгчөөр сонгогдсон Янукович тангараг өргөх үеэрээ Украиныг төвийг сахисан орон байлгах нь түүний гол зорилго гэдгээ мэдэгдэж байсан юм.

АНУ-ын Гадаад хэргийн сайд Хиллари Клинтон Киевт айлчлахын

(2010 оны 7 сарын 1) өмнөх өдөр нь Украины Парламент эцсийн хэлэлцүүлгээр шилжилтийн үеийн барууныг баримтлагч Засгийн газрын НАТО-д элсэх төлөвлөгөөг унагаасан байжээ. Украины парламентын 450 гишүүний 259 гишүүн НАТО-д элсэхийн оронд эвслээс ангид байх тухай хуулийн төлөө саналаа өгчээ (Steiner 2010: 9). Украины орос хэлт зүүн хэсгээс гаралтай Ерөнхийлөгч Янукович энэ хуулийг санаачилсан байна. Гэхдээ Янукович "НАТО-той бүтээлч харилцаа"-гаа цаашид үргэлжлүүлэхийг эрмэлзэж байжээ (Steiner 2010: 9). 2010 оны 7 дугаар сарын 2-нд Хиллари Клинтон ирээд НАТО-гийн саналыг дахин тавьж, "НАТО-гийн хаалга Украины хувьд нээлттэй байх болно. Гэхдээ та бүхэн өөрсдөө шийдвэрээ гаргах ёстой" гэж Украины гадаад хэргийн сайд Константин Грищенкод хэлсэн байдаг (Steiner 2010:9). Янукович газар зүйн байрлалаас шалтгаалан Украин улс *Өрнө Дорны хооронд прагматикаар төвийг сахих* нь хамгийн тохиромжтой гэдгийг ойлгохыг Клинтоноос хүсчээ. Украин 2010 оны 7 дугаар сарын 24-нд оросын *Хар тэнгисийн усан флотыг* 2042 он хүртэл Севастопельд үлдээхээр ОХУ-тай тохиролцсон байна. Үүнийх нь төлөө Оросууд Украины аж үйлдвэрийн салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалт хийхээ мэдэгдсэн (Steiner 2010: 9-ийг үзнэ үү). ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин 2014 оны 2 дугаар сарын 24-ний *Евромайдан* хөдөлгөөний дэмжлэгтэй төрийн удирдлага солигдсоныг хууль бус бөгөөд ардчиллын журмаар сонгогдсон Оросыг баримтлагч Ерөнхийлөгч Януковичыг Киевээс зугтахад хүргэснийг "хүчээр төрийн эргэлт хийсэн" *(Coup)* гэж дүгнэсэн юм (Mearsheimer 2014: 77). Үүнд 2014 оны 3 дугаар сарын 21-нд *Крымийг эзлэн* авснаар Путин хариу барьсан бөгөөд тэрээр Оросын цэргийн баазын оронд НАТО-гийн бааз байгуулагдаж болзошгүй гэдгээс айсан юм (Mearsheimer 2014: 77-г үзнэ үү).

Яг тэр өдөр Украин, ЕХ-ны хооронд Европын холбооны *ассоциацын гэрээний*[15] улс төрийн хэсэгт гарын зурсан юм. 2014 оны 2 дугаар сард нуран унасан Януковичийн Засгийн газар ЕХ-той нягт хамтран ажиллахаа мэдэгдэж байсан хэдий ч 2013 оны 11 сарын 21-нд Вильнюст болсон ЕХ-ны Зүүний түншлэлийн орнуудын дээд хэмжээний уулзалтын үеэр аль хэдийн ярьж тохирсон байсан ЕХ-той *ассоциацын гэрээнд* гарын үсэг зурахаас татгалзсан юм (Kowal/Wapinski 2014: 11-ийг үзнэ үү). Энэ нь Оросын талын дарамтаас болсон бөгөөд Янукович ийм шийдвэр гаргасны улмаас Украинд эсэргүүцлийн хөдөлгөөний өргөн давалгаа бий болж, Янукович зугтахад хүрчээ. Киевийн Парламент үүнийх нь төлөө Януковичийг огцруулж байгаагаа зарласан. 2014 оны 5

15 EU Association Agreement-ийг ассоциацын гэрээг гэж орчуулав (орч.)

дугаар сарын 29-нд ОХУ, Казахстан, Беларусь улсын үүсгэн байгуулсан *Евразийн эдийн засгийн холбоонд* Украиныг элсэхийг Оросууд ятгаад дийлээгүй юм. Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө, ажиллах хүчний чөлөөт хөдөлгөөнийг бий болгох зорилготой энэхүү холбооны гэрээ нь 2010 оны *Гаалийн холбоо,* 2012 оны *Эдийн засгийн нэгдсэн орон зай* дээр үндэслэн бий болсон агаад 170 сая хэрэглэгчдэд зориулан 2015 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн (Davydchyk/Romanova 2014:14-ийг үзнэ үү). *Евразийн эдийн засгийн холбоо* байгуулагдсантай холбогдуулж ЕХ-г тэлэх асуудлыг хариуцсан коммисар Штефан Фюле *(Stefan Fuele)* Украин, Гүрж, Молдавыг урт хугацаанд ЕХ-ны бүрэн эрхт гишүүн болгохоо мэдэгдсэн юм.

“Бид Зүүн Европын орнуудыг өөрчлөн байгуулахыг нухацтай бодож байгаа бол бидний хамгийн хүчтэй хэрэгсэл болох “тэлэлтийг” жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх ёстой” гэж тэрээр хэлжээ (Hauser 2014: 11).

Украины хямрал улам гүнзгийрч, Крым Украинаас салан тусгаарлах нь тодорхой болох үед хийгдсэн уг алхам Москвагийн зүгээс хүлээн зөвшөөрсөн 2014 оны 3 дугаар сарын 1-ны санал асуулгаар шийдвэрлэгдсэн гэж Оросууд үздэг юм. Тэр үед НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга Андерс Фог Расмуссмен “төвийг сахихыг” Украины зэвсэгт хүчинд уриалж байжээ:

„Украинд асар их цус урсч байгаад би их харамсч байна. Оролцогч талуудыг энэ хүчирхийллээ даруй зогсоохыг уриалж байна. Мэдээж Засгийн газар нь хэт хүч хэрэглэхгүй байх, зэвсэгт хүчний “төвийг сахисан байдлыг” хангах онцгой үүрэгтэй“ (NATO 2014c).

Хэдэн сарын дараа буюу 2014 оны зун Украины зүүн хэсэг, ялангуяа Донецк, Луганск мужид оросыг баримтлагч салан тусгаарлагчид, хөлсний цэргүүдийн эсрэг ширүүн тулаан хийх болж, Амстердамаас Куала Лумпур чиглэлд нисч явсан 289 зорчигчтой Малайзын *Boeing 777-200* онгоцыг Оросын хилээс 40 км зайд буудан унагасан зэрэг явдлаас хойш зэвсэгт хүчин төвийг сахиж суух аргагүй болсон (Die Zeit 2014-ийг үзнэ үү). 2014 оны 4 дүгээр сарын 17-нд Страсбургт Европын Зөвлөл хуралдаж Украины хямралтай уялдуулан ОХУ-ын төлөөлөгчдийн саналын эрхийг олонхийн саналаар (дэмжсэн-145, -22, түтгэлзсэн-21) хассан юм. Уг шийдвэрийг Австрийн төлөөлөгч Штефан Шенахын *(Stefan Schennach, SPÖ)* мэдээлэл дээр үндэслэн гаргажээ. Тэр үед Австри *Европын Зөвлөлийг* тэргүүлж байсан юм (Die Presse 2014c:7). Оросын

төлөөлөгчдийн саналын эрхийг нь тодорхой хугацаагаар буюу 2014 он дуустал хассан байна. Уг хугацаа дууссаны дараа оросын 18 төлөөлөгчийг түтгэлзүүлэх шаардлагыг бас тавьсан боловч хүлээж аваагүй аж. 2014 он дуустал Оросын төлөөлөгчдийг юуны өмнө сонгуулийн ажиглалт хийх, албан болон тэргүүлэгчдийн хуралдаанд оролцохыг хорьсон байна (Die Presse 2014c: 7-г үзнэ үү). Оросууд Крымийг өөртөө нэгтгэсэн явдлыг *Европын Зөвлөлийн* парламентын гишүүд "олон улсын эрх зүйг зөрчсөн үйлдэл" гэж шүүмжлэхийн зэрэгцээ Киевийн шинэ Засгийн газрыг бүрэн эрхт, хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрсөн юм (Die Presse 2014c: 7-г үзнэ үү).

Украины Ерөнхийлөгч Петр Порошенко 2014 оны 9 дүгээр сарын 18-нд АНУ-д айлчлах үеэрээ Украины зүүн хэсэгт оросыг баримтлагч салан тусгаарлагчдын эсрэг хийж буй тулаанд цэргийн тусламж үзүүлэхийг Америкийн удирдагчаас хүссэн байна:

„Тэдэнд илүү их хэмжээний галт болон галт бус зэвсэг, цэргийн техник хэрэгсэл хэрэгтэй байна. Та намайг зөв ойлгоорой. Шөнөөр харах хэрэгсэл, хөнжил чухал боловч хөнжлөөр байлдаанд ялахгүй шүү дээ“ (Shear 2014: 4).

2014 оны 9 дүгээр сар хүртэл АНУ-ын Засгийн газар 70 сая ам.долларын галт зэвсгийн бус хэрэгслээр тусалсан бол АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама ОХУ-ын эсрэг эдийн засгийн хориг тавих зорилгоор ЕХ-той эвсэл үүсгэжээ (Shear 2014: 4-ийг үзнэ үү). Түүнчлэн АНУ-аас Украины зэвсэгт хүчин, хилийн хамгаалалтын хүчинд зориулж дахин 46 сая ам.долларын туслалцаа үзүүлсэн бөгөөд 2014 оны 9 дүгээр сарын 18-нд Иргэний батлан хамгаалах, хүмүүнлэгийн туслалцаанд зориулж Цагаан ордон дахин 7 сая ам.доллар гаргасан байна (Shear 2014: 4-ийг үзнэ үү). Порошенко АНУ-д айлчилж ирээд улс оронд нь тулгараад байгаа сорилтыг:

„Гибрид төлөөний дайн, терроризм, радикал болон хэт даварсан үндэсний хөдөлгөөн, үндэсний болон олон улсын гэрээ хүчгүйдэх, үндэсний онцлог бүдгэрэх бүр цаашлаад устах зэрэг нь Европт тулгарч буй сорилтууд болж байна. Хэрэв бид эдгээрийг зогсоохгүй бол аюул занал нь Европын хилийг нэвтэрч цаашлаад дэлхий дахинд тархах болно“ гэв (Shear 2014: 4).

Нэг талд нь ЕХ, НАТО нөгөө талд нь ОХУ оршдог Украины геополитикийн онцлог байдлыг харгалзан төвийг сахих сонголт байж болох талаар ЕХ-ны гишүүн орны засгийн газрыг төлөөлөн Австрийн гадаад хэргийн сайд Себастиан Курц *(Sebastian Kurz)* анх удаа санал гаргасан байна. Тэрээр Украины удирдлагатай ярилцахдаа, "Австрид цэргийн төвийг

сахисан явдал сайн үр дүн авчирсан” ба “НАТО-д гишүүнээр элсэх нь Оросуудыг өдөөсөн хэрэг болох байсан” хэмээн сануулжээ (Ultsch/Schneider 2014-ийг үзнэ үү). АНУ-ын улс төр судлаач Жон Мэршаймэр *(John J. Mearsheimer)* бас иймэрхүү санаа хэлсэн байдаг:

„АНУ болон түүний холбоотнууд Украиныг баруунжуулах төлөвлөгөөгөө орхиж, үүний оронд тус улсыг хүйтэн дайны үед Австрийн баримталж байсан байр суурь шиг НАТО, Оросын хоорондох төвийг сахисан жийргэвч улс болгох хэрэгтэй. Украин Оросын эсрэг дэлгэмтэй байхыг дэмжиж чадахгүй учраас Путинд энэ нь ямар чухал гэдгийг барууны удирдагчид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Оросын ч биш, Барууны лагерьт ч хамаарахгүй тусгаар тогтносон Украин улс болгох нь гол зорилго байх ёстой“ (Mearsheimer 2014: 87).

2014 оны зун Украин ЕХ-нд нэгдэх хэлэлцээрт гарын үсэг зурснаар арай гэж ЕХ-той ойртсон тэр үед Оросууд Казахстан, Беларусьтай хамтран *Евразийн эдийн засгийн холбоо* гэх өөрийн интеграцыг эхлүүлсэн юм. 2014 оны 9 дүгээр сарын 4,5-ны өдөр *Newport/Wales-д* болсон НАТО-гийн дээд хэмжээний хуралдаан дээр энэ талаар дахин “маш хурцаар хэлэлцэж”, Оросын цэргийн Украинд явуулж буй интервенц улам бүр хурцдмал, хууль бус болж байгааг шүүмжлэхийн (“Украин дахь шатлан өргөжиж буй, хууль бус цэргийн интервенц”) зэрэгцээ Украины нутаг, хилийн дагуу газар нутгаас цэргийн анги нэгтгэлээ эргүүлэн татахыг Оросоос шаардсан. “Украины бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд халдсан нь олон улсын эрх зүйг ноцтой зөрчсөн явдал төдийгүй Евро-атлантын аюулгүй байдалд томоохон сорилт учруулж байна” (NATO 2014a: Punkt 16). Мөн түүнчлэн салан тусгаарлагчдад зэвсэг техник нийлүүлэх, дайчид, мэргэжлийн боловсон хүчин болон мөнгөөр дэмжихээ зогсоохыг Оросуудаас шаардсан байна. ОХУ-ыг нөлөөгөө ашиглан салан тусгаарлагчдад нөлөө үзүүлж нөхцөл байдлыг намжаах, Украины олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хил хязгаарыг хүндэтгэн үзэж, Украины газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг сэргээх зорилготой улс төр, дипломатын арга хэрэгслийг хэрэгжүүлэх чиглэлд алхам хийхийг мөн уриалав. (NATO 2014a: Punkt 16-ийг үзнэ үү).

Украины хямралаас үүдэн ЕХ 2014 оны 9 дүгээр сарын 12-нд Украинтай хийсэн ЕХ-нд нэгдэх хэлэлцээний эрчийг “бага зэрэг намжаасан” (Laczynski/Vieregge 2014:8): ЕХ-ны худалдааны коммиссар Карел Гухт *(Karel De Gucht)* хэлэхдээ Украинтай байгуулсан чөлөөт худалдааны гэрээ бүрэн хэрэгжиж эхлэх хугацааг 2015 оны эцэс хүртэл хойшлуулсан талаар мэдэгдсэн байна. Энэ талаар ЕХ, Украин, ОХУ санал нэгджээ. (Laczynski/Vieregge 2014:8-ыг үзнэ үү). Оросууд хариуд

нь шийтгэлийн арга хэмжээ авахаа больсон. Оросууд урд нь хэрвээ Украин ЕХ-нд нэгдэх хэлэлцээрээсээ 2014 оны 11 дүгээр сарын 1 гэхэд татгалзахгүй бол Украины эсрэг хориг нэмж тавихаар заналхийлсэн байдаг. 2014 оны 9 дүгээр сарын эхэнд ОХУ-ын зүгээс Украин ЕХ-нд нэгдэх гэрээг саармагжуулах зорилгоор Оросын эрх ашигт нийцэх 2000 төрлийн өөрчлөлтийг санал болгосон 60 хуудас бичгийг ЕХ-нд явуулсан юм (Laczynski/Vieregge 2014:8-ыг үзнэ үү). ЕХ, Украины хооронд явагдах чөлөөт худалдаа зөвхөн либералчилсан байгаа салбаруудыг хамрах ёстой гэжээ. Мөн түүнчлэн “ОХУ-ын санааг зовоосон асуудалд нааштай хандаж болохуйц уян хатан байхаар уг гэрээ хийгдсэн байх”-ыг хүссэн байна (Laczynski/Vieregge 2014:8). ЕХ, Украины хооронд хийгдсэн ЕХ-нд нэгдэх болон чөлөөт худалдааны тухай 15 бүлэг, 14 хавсралт болон 3 нэмэлт протокол бүхий 2135 хуудастай гэрээг 2014 оны 9 дүгээр сарын 16-нд Страсбург дэх Европын Парламент, Киев дэх Верховна Рада соёрхон баталсан юм (Laczynski 2014a: 7-г үзнэ үү). Энэхүү гэрээнд юуны өмнө “хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан Украин улс Европын стандарт, хэм хэмжээ, үнэт зүйлд нийцэж ирэх, мөн түүнчлэн Майданы эрх чөлөөний төлөө тэмцэгчдэд гэрээг соёрхон батлана гэсэн амлалтаа биелүүлсэн” тухай тусгагдсан талаар Европын Парламентын Австри гишүүн Отмар Карас (*Othmar Karas -EVP/OVP*) онцолсон байна (Laczynski 2014a: 7-г үзнэ үү).

# 10. Дүгнэлт

Энэхүү номд судлагдсан орнууд ЗХУ-ын задралаас хойш гео-стратегийн байрлалаасаа хамаарч төвийг сахих явдлыг харилцан адилгүй тайлбарлаж ирсэн, одоо ч тийм байна. 1989 оноос Европын тогтолцоо өөрчлөгдөж эхлэх хүртэл төвийг сахиж ирсэн Финлянд, Швед, Австри зэрэг орон Европын холбоонд элсэхийг эрмэлзэх болов (Gehler/Steininger 2000: 9-ийг үзнэ үү). Австри улс *төвийг сахих чиг баримжаагаа* хадгалж үлдсэн бол Финлянд, Швед улсууд 1995, 2002 онд төвийг сахихаас улс төрийн аргаар татгалзсан. Лиссабонд баталсан Европын холбооны гэрээнд *Эв нэгдлийн заалт*, *Туслан дэмжих үүргийн* тухай заалтууд шинээр оров. Европын холбооны талаарх Лиссабоны гэрээнд туссан Туслан дэмжих үүргийг Австрийн зүгээс дараах байдлаар тайлбарлаж байна: “Төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч улс, тухайлбал Австри, туслан дэмжих эсэх, үүнийгээ хэрхэн хэрэгжүүлэхээ тухай бүрт нь өөрсдөө шийдвэрлэнэ” (Bundeskanzleramt/Bundespressedienst 2007:49). Иймээс Австри улс “төвийг сахих бодлоготой нь харшлах тохиолдолд аливаа дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээхгүй” ажээ (Bundeskanzleramt/Bundespressedienst 2007:49). Учир нь “Аюулгүй байдал, батлан хамгаалахын нэгдмэл бодлого *(GSVP)*-дахь зарим орны онцгой байр суурийг харгалзах тухай заалт нь энэхүү нэгдмэл бодлогын бүх хэсэгт хамаарна. Үүгээрээ Австри улсын төвийг сахих үүргийг нь баталгаажуулж байна” (Bundeskanzleramt/Bundespressedienst 2007:50). Европын эрх зүйг судалдаг австрийн эрдэмтэд ч үүнтэй санал нэг байна:

“Туслан дэмжих үүрэг нь тодорхой улсуудын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын онцлог шинжийг хөндөхгүй байх заалт нь Австрийн хувьд маш чухал зүйлийг тодруулж өгч байна”. Энэ томъёолол төвийг сахих талаарх Үндсэн хуультай дүйцэхүйц хуулийн заалтууд Лиссабоны гэрээтэй зөрчилдөхөөргүй болгож байгаа юм” (Thun-Hohenstein/Cede/Hafner 2008: 276).

Эв нэгдлийн талаарх заалтад ч энэ нь тодорхой харагдана:

“Террорист халдлага, байгалийн гамшиг, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгийн үед гишүүн улсууд харилцан туслах (үүнд цэргийн арга хэрэгсэл орно) үүрэгтэй. Аюулд өртсөн улсад хэрхэн туслах арга замаа гишүүн улс бүр өөрсдөө сонгоно“ (Bundeskanzleramt/Bundespressedienst 2007: 50).

Үүнээс үзэхэд Европ тивд цорын ганц батлан хамгаалах эвсэл нь НАТО юм. Гэсэн хэдий ч төвийг сахигч, эвсэлд үл нэгдэгч орнуудын хувьд Европын холбоо нь *Хямралыг зохицуулах чиглэлээр аюулгүй байдлыг*

хангах эвсэл болж байна. Австри улс ЕХ-ны *EUFOR Althea* (Босни Герцеговина-д) ажиллагааны коммандлалд орж, цэргийн ихэнхийг гаргасан юм.

